

## УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, ОБЪЕКТЫН ТЕХНИК АШИГЛАЛТЫН ДҮРЭМ, ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

### 1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн нуур, гол мөрний усан замын тээвэрт ашиглагдаж байгаа усан замын тээврийн хэрэгсэл, объектын техникийн ашиглалт, тэдгээрт тавигдах техникийн шаардлагатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү дүрэм нь усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлыг хангах, хүрээлэн буй усан орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх, зорчиж буй хүмүүсийн эрүүл мэнд, амь насыг хамгаалах, тээвэрлэж буй ачаа, эд хөрөнгийн болон объектын бүрэн бүтэн байдлыг хамгаалахад чиглэгдсэн техникийн ашиглалт, техникийн шаардлагыг тодорхойлно.

1.3. Дүрэм нь усан замын тээврийн хэрэгсэл, объектыг техникийн эвдрэл гэмтэлгүй, ашиглалтын байнгын бэлэн байдалд байлгахад чиглэгдсэн, түүнийг үр дүнтэй, осол авааргүй олон улсын болон үндэсний хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн зориулалт, өгөгдсөн техник-эдийн засгийн үзүүлэлтүүдийн дагуу ашиглахад зориулагдсан техник - зохион байгуулалтын цогц арга хэмжээг тодорхойлно.

1.4. Усан замын тээврийн хэрэгсэл, объектын техникийн ашиглалтын дүрэм, техникийн шаардлагыг Усан замын тээврийн тухай<sup>1</sup> хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.13, 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтад нийцүүлэн боловсруулав.

1.5. Энэхүү дүрмийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох асуудлыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

1.6. Гол мөрөн, нуур цөөрмийн усан замын тээвэр болон түүнд холбоотой шинээр гарах аливаа нэгэн техник ашиглалтын дүрэм, техникийн шаардлага, зааврууд энэхүү дүрмийн заалтын агуулга, зарчимд нийцсэн байвал зохино.

1.7. Энэхүү дүрэм нь Усан замын тээврийн тухай<sup>2</sup> хуулийн 8.1-д заасан Монгол Улсын Төрийн далбаа мандуулан хөвж буй усан замын тээврийн хэрэгсэлд үйлчилнэ.

1.8. Энэхүү дүрмийг усан замын тээврийн хэрэгсэл, объектыг эзэмшигч /өмчлөгч/ ашиглагч усан замын тээврийн үйлчилгээ эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллага, тэдгээрийн нийт ажилтан дагаж мөрдөнө.

### 2. Усан замын тээврийн хэрэгсэл, объектын техник - ашиглалтыг зохион байгуулах

<sup>1</sup> Усан замын тээврийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2017 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Усан замын тээврийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2017 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

Техник-ашиглалт нь усан замын тээврийн хэрэгсэл, объектын ашиглагдах бүх хугацааны туршид, түүнийг эвдрэл, гэмтэл, зогсолтгүй хэвийн ажиллуулахын тулд авч хэрэгжүүлж буй техникийн болон зохион байгуулалтын иж бүрэн цогц арга хэмжээ юм.

Эзэмшигч /өмчлөгч/ нь усан замын тээврийн хэрэгсэл, объектын техникийн ашиглалтын зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ.

## **2.1. Усан замын тээврийн хэрэгсэл эзэмшигч /өмчлөгч/-ийн үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээ**

2.1.1. Эзэмшигч /өмчлөгч/ нь усан замын тодорхой нэг тээврийн хэрэгсэл, объектын техникийн ашиглалтыг хариуцаж хангаж байх үүрэг хүлээсэн этгээдийг томилно.

2.1.2. Усан замын тээврийн хэрэгсэл, объектын ажиллах горим, бүрэлдэхүүний хуваарь, ээлжийн ажиллагааны дэг, түүнчлэн техникийн үйлчилгээ хийх тогтолцоог батална.

2.1.3. Усан замын тээврийн тухай хууль тогтоомжийн биелэлт болон усан замын тээврийн хэрэгсэл, объектын баримт бичгийн үйлчлэх хугацааг хянана.

2.1.4. Усан замын тээврийн хэрэгсэл, объектыг үзлэгт хамруулна.

2.1.5. Усан замын тээврийн хэрэгслийг зайлшгүй шаардлагатай хангалтуудаар хангах ажлыг зохион байгуулна.

2.1.6. Эзэмшигч /өмчлөгч/ болон усан замын тээврийн хэрэгсэл жолоодогч хооронд холбоо барих асуудлыг зохион байгуулна.

2.1.7. Усан замын тээврийн хэрэгслийг норм, нормативын болон зохион бүтээгч-техникийн баримт бичгүүдээр хангаж, олон улсын болон үндэсний хууль, дүрэм, журмыг усан замын тээврийн хэрэгсэл жолоодогчдод танилцуулна.

2.1.8. Усан замын тээврийн хэрэгсэл, объектыг засварлах ажлыг зохион байгуулж, үнэ өртөг, гүйцэтгэлийн чанар, хугацааг хянана.

2.1.9. Усан замын тээврийн хэрэгслийн осолд дүн шинжилгээ хийж, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж мөрдүүлнэ.

2.1.10. Усан замын тээврийн хэрэгсэл дээр техникийн сургалт зохион байгуулна.

2.1.11. Усан замын тээврийн хэрэгсэл, объект дээр эд хөрөнгийн тооллого, бүртгэл хийх заавар, хугацааг тогтооно.

## **2.2. Багийн гишүүдийн үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээ**

2.2.1. Техникийн ашиглалтын ерөнхий удирдлагыг усан замын тээврийн хэрэгслийн ахмад, жолоодогч (цаашид “ахмад” гэх) удирдана. Ахмад нь усан замын тээврийн хэрэгслийг удирдах, жолоодох, хөвөлтийн аюулгүй байдлыг хангах, тавцан дээр дэг журмыг сахиулах, хүрээлэн буй орчныг хамгаалах, усан замын тээврийн хэрэгсэл болон тавцан дээр зорчиж буй хүмүүс, тээвэрлэж буй ачаанд хор хөнөөл учруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

2.2.2. Ахмад нь багийн гишүүн бүрт эрхлэх ажил, үүргийг нь хариуцуулж өгнө.

2.2.3. Ахмад нь ээлжийн ажиллагааны хуваарийг гаргаж, батална.

2.2.4. Багийн гишүүд нь дараах үүрэгтэй. Үүнд:

2.2.4.1. усан замын тээврийн хэрэгслийг техникийн бүрэн бүтэн байдалд, цэвэрхэн байлгаж, эзэмшигч /өмчлөгч/-ээс баталсан төлөвлөгөө болон техник, тоног төхөөрөмж, хэрэгслийг ашиглах зааврын дагуу техникийн үйлчилгээ хийх;

2.2.4.2. бүх техник, тоног төхөөрөмж, хэрэгслийг зориулалтаар нь, тогтоосон техникийн үзүүлэлтүүдийн дагуу үр дүнтэй, осол авааргүй хэрэглэж,

зайлшгүй шаардлагатай бүх төрлийн нөөц, хангалтын эд зүйлс байгаа эсэхийг хянана;

2.2.4.3. усан замын тээврийн хэрэгслийн ажлын дэг болон ус, шатахуун, тослох материалыг зарцуулах тогтоосон хэмжээ, түүнчлэн тэдгээрийн ангилал, зэрэг, чанарыг сахин биелүүлнэ. Түлш, тослох материалын зарцуулалтын тооцоог эзэмшигч /өмчлөгч/-ийн тогтоосон журмаар хөтөлнэ;

2.2.4.4. техникийн, зохион бүтээгчийн, технологийн болон бусад хэм хэмжээ тогтоосон баримт бичгүүдээр тавигдсан шаардлагыг биелүүлнэ;

2.2.4.5. техникийн сургалтад оролцоно. Техникийн сургалтын төлөвлөгөө, сургалт явуулах журмыг усан замын тээврийн хэрэгслийн ахмад батална;

2.2.4.6. эрхэлж буй ажил үүргийн хуваарийн дагуу усан замын тээврийн хэрэгсэл дээрх баримт бичгийг хөтөлнө.

2.2.5. Усан замын тээврийн хэрэгслийн техник хэрэгсэл, тавцангийн тоног төхөөрөмж, хэрэгсэл, системийн техник - ашиглалтын ажлыг механикийн удирдлага дор гүйцэтгэнэ.

2.2.6. Усан замын тээврийн хэрэгслийн удирдах бүрэлдэхүүний гишүүн томилогдох үедээ дараах ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

2.2.6.1. өөрийн хариуцах машин механизм, системд үзлэг хийж, тэдгээрийг ажиллуулж үзнэ, (хэрэв хүлээн авч байгаа үед бол тэдгээрийг үйл ажиллагаанд шалгаж болно);

2.2.6.2. өөрийн хариуцах машин механизм, системийн иж бүрдлийг хянаж, тавцан дээрх баримт бичгүүдийн үйлчлэх хугацааг шалган, хариуцаж буй эд зүйлсийн данс бүртгэл хөтөлнө;

2.2.6.3. бүх төрлийн нөөц, хангалт байгаа эсэхийг хянана;

2.2.6.4. хариуцах машин механизм, системээ хүлээн авахдаа, техникийн байдал, ажил гүйцэтгэхэд бэлэн эсэх, эсвэл засвар үйлчилгээ хийх шаардлагатайг заасан акт үйлдэж механикт эсвэл ахмадын ахлах туслахад илтгэх ба тэд ахмадад илтгэнэ.

2.2.7. Ахмад, эсхүл механик солигдсон үед удирдах бүрэлдэхүүний гишүүн /багийн гишүүд/ өөрийн хариуцаж буй машин механизм, тоног төхөөрөмж, хэрэгслийн техникийн байдлын талаар шинээр томилогдсон ахмад, механикт илтгэнэ.

2.2.8. Усан замын тээврийн хэрэгсэл дээр хангалтын эд зүйлс, тоног төхөөрөмж, солих нөөц сэлбэг, механизм, материалыг хүлээн авахдаа үйлдвэрлэгчийн болон бусад шаардлагатай гэрчилгээг шалгана.

### **3. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хэрэглээ**

Усан замын тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, хэрэгслийг тэдгээрийн техник-ашиглалтын үзүүлэлтийн дагуу ажиллуулж буй багийн гишүүдийн мэдлэг, чадварыг техникийн хэрэглээг гэнэ. Техникийн хэрэглээг багийн гишүүд хэрэгжүүлэх ба усан замын тээврийн хэрэгслийн техник, тоног төхөөрөмж, хэрэгслийг зохион бүтээгчийн болон бусад хэм хэмжээний баримт бичгүүдэд урьдчилан заасан техник-ашиглалтын үзүүлэлтүүдийн дагуу зориулалтаар нь хэрэглэн, ээлжийн ажиллагааны хугацаанд усан замын тээврийн хэрэгслийн үйл ажиллагааг бүрэн хангахын тулд авч хэрэгжүүлж буй техник-ашиглалтын цогц ажил, арга хэмжээ юм.

3.1. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хэрэглээг ээлжийн болон жижүүрийн удирдлагын байрнаас удирдана. Ээлжийн удирдлагын байрнаас удирдахдаа – ээлжинд гарч буй багийн гишүүнийг байнга байлгах ба жижүүрийн байрнаас удирдахад – түүнийг байнга байлгах шаардлагагүй.

3.2. Усан замын тээврийн хэрэгсэл дээрх ээлжийн болон жижүүрийн удирдлагын байрыг автоматжуулалтын тогтоосон ангилалтай нь уялдуулан зохион бүтээх төсөлд тодорхойлдог.

3.3. Багийн гишүүдийн хэрэгжүүлж буй техникийн хэрэглээг үйлдвэрлэгчийн зааварт нийцүүлэн явуулж, үйлдлийн бэлэн байдлыг шалгах, үйлдэл хийлгэх, түүнээс гаргах, усан замын тээврийн хэрэгслийн техник, тоног төхөөрөмж, хэрэгслийн ажиллагааны горимыг өөрчлөх, хэвийн болгох, өгөгдсөн болон бодит үзүүлэлтүүдийг харьцуулах, хазайлт хэлбэлзэлийг тэмдэглэх, үнэлэх, тэдгээрийг бүртгэх, хянах, техникийн хэвийн байдлыг хангахад оршино.

3.4. Ашиглалтын явцад илрүүлсэн болон эд анги ажиллагаагүй болсонтой холбоотой усан замын тээврийн хэрэгслийн техник, тоног төхөөрөмж, хэрэгслийн гэмтэл, эвдрэлийг ээлжийн ахлагчийн зөвшөөрлөөр засварлана. Нөхцөл байдал тухайн эд ангийг ашиглалтаас гаргаж засварлах боломжгүй болгож байгаа бол ээлжийн ахлагч, тавцан дээрх хүмүүсийн аюулгүй байдлыг хангах, усан замын тээврийн хэрэгсэл, түүний машин, механизмуудыг болзошгүй гэмтэл, эвдрэлээс урьдчилан сэргийлэх талаар бүх арга хэмжээг авна.

3.5. Усан замын тээврийн хэрэгслийн нөөц техник, тоног төхөөрөмж, хэрэгслийг жилийн хугацаанд ажилласан цаг хугацаа нь ойролцоогоор тэнцүү байхаар ээлжлэн ажиллуулна.

3.6. Усан замын тээврийн хэрэгслийн техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, механизм, системийн ажиллаж буй байдал, ажлын горимд тавих хяналтыг осол аваараас урьдчилан сэргийлэх дохиоллын хэрэгсэл, суурилуулсан хяналт-хэмжилзүйн хэрэгслийн заалтаар болон механизм, системийн ерөнхий ажиллагаа, байдлыг ажиглах замаар хэрэгжүүлнэ.

3.7. Осол, аваараас урьдчилан сэргийлэх дохиоллын болон аваарийн хамгаалалтын бүх хэрэгслийг байнгын бэлэн байдалд байлгах ба үйлдвэрлэгчийн зааврын дагуу үе үе шалгаж байна. Хяналтын үзлэг болон урьдчилан сэргийлэх засварын хугацаанд зөвхөн ээлжийн ахлагчийн зөвшөөрлөөр унтраах ба энэ тухай усан замын тээврийн хэрэгслийн дэвтэр, хөдөлгүүрийн дэвтэрт зохих бичилт үйлдэж ахмад, механик, ахлах механикт илтгэнэ.

3.8. Аваарийн хамгаалалтын хэрэгслийг тохируулж лацдсан байна. Ашиглалтын хугацаанд лацыг санамсаргүй хөндсөн тохиолдолд хөдөлгүүрийн дэвтэрт тэмдэглэл үйлдэнэ. Лацыг эхэлж хүрэлцэн очсон боомтдоо сэргээнэ.

3.9. Хяналт - хэмжил зүйн бүх хэрэгслүүд хэвийн ажиллаж байх ёстой ба хүчин төгөлдөр гэрчилгээтэй буюу үзлэгийн тамга, дардастай байна.

3.10. Осол аваараас урьдчилан сэргийлэх дохиоллын болон аваарийн хамгаалалтын хэрэгсэл автоматаар гэнэт ажилласан бол ээлжийн механик шалтгааныг нь тодорхойлж, техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, механизм, системийг гэмтэх, эвдрэхээс хамгаалах, илрүүлсэн гэмтэл, эвдрэлийг засах зайлшгүй шаардлагатай арга хэмжээг авч, энэ тухай механик /ахлах механик/-т мэдээлнэ. Эдгээр хэрэгсэл нь удаа дараа гэнэт автоматаар ажиллаж байгаа бол ээлжийн харуул тэдгээрийг унтрааж, механизм, системийн ажиллагааг хэвийн болгох ба ахмадын ээлжийн туслах, механикт энэ тухай мэдэгдэж, хөдөлгүүрийн болон усан замын тээврийн хэрэгслийн дэвтэрт зохих тэмдэглэгээ хийнэ. Осол аваараас урьдчилан сэргийлэх дохиоллын болон аваарийн хамгаалалтын хэрэгслийг нь салгасан /унтраасан/ механизм, системийн ажиллагааны үзүүлэлтүүдийн хяналтыг чангатгах арга хэмжээг ээлжинд гарч буй механик авна.

3.11. Усан замын тээврийн хэрэгсэл, объект, тээвэрлэж буй ачаа болон хүмүүсийн амь насанд аюул учрахаар эвдрэл, гэмтэл үүссэн нөхцөлд ээлжинд гарч буй ахмадын туслах бие дааж, эсвэл хэн нэгэнд осол аваараас урьдчилан сэргийлэх дохиоллын болон аваарийн хамгаалалтын хэрэгслийг салгах удирдамжийг өгнө. Салгасан /унтраасан/ тодорхой тохиолдол бүрт ээлжинд гарч буй ахмадын туслах ахмад, эсхүл механик /ахлах механик/-т нэн даруй илтгэнэ.

Усан замын тээврийн хэрэгслийн болон хөдөлгүүрийн дэвтэрт энэ тухай тэмдэглэл хийнэ.

3.12. Гол хөдөлгүүр эвдэrsэн эсвэл тодорхойгүй шалтгаанаар гэнэт унтарсан бол ээлжинд гарч буй ахмадын туслах эвдрэл гэмтлийн шалтгааныг тогтоож, засварлах зайлшгүй шаардлагатай арга хэмжээг нэн даруй авна. Бусад нэн хэрэгцээт техник, тоног төхөөрөмж, хэрэгсэлд тодорхойгүй шалтгаанаар гэнэт эвдрэл, гэмтэл гарсан бол ээлжинд гарч буй багийн гишүүд нөөц техник, тоног төхөөрөмж, хэрэгслийг ажиллуулах бөгөөд ахмад, эсхүл механик /ахлах механик/-т энэ тухай нэн даруй илтгэнэ. Усан замын тээврийн хэрэгслийн болон хөдөлгүүрийн дэвтэрт энэ тухай тэмдэглэл хийнэ.

3.13. Бүх техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, механизмыг системийг зориулалтаар нь ашиглана. Тэдгээрийг ажил, үйлчилгээнд бэлтгэх, оруулах, ажиллах горимд нь хяналт тавих, ажил, үйлчилгээнээс гаргах, зогсоо талаарх товч зааварыг дэргэд нь өлгөсөн байна. Хатаах систем, бохирын систем болон бусад бохирын системийн бүдүүвч зургууд дээр хүрээлэн буй орчныг бохирдуулахаас хамгаалсан цорго, таглааг лацаах хэсгийг заасан байна.

3.14. Зогсолтын горимд байх үед зогсоолын нөхцөл болон боомтод үйлчилж буй дүрмээс хамааран ахмад усан замын тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг байнгын ба тодорхой хугацаатай гэж зэрэг тогтооно.

#### **4. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ**

Усан замын тээврийн хэрэгсэл, объектыг техникийн хувьд бүрэн бүтэн байлгах зорилгоор багийн гишүүд болон эргийн байгууллагын ажилтнуудын гүйцэтгэж буй иж бүрэн ажил, арга хэмжээг техникийн үйлчилгээ гэнэ. Техникийн үйлчилгээ нь усан замын тээврийн хэрэгслийг техникийн хувьд бүрэн бүтэн байлгах, техникийн байдалд нь хяналт тавих, эвдрэл, гэмтлийг нь илрүүлж засварлах, элэгдсэн болон эвдэrsэн эд анги, зангилааг солиход чиглэгдсэн иж бүрэн цогц ажил юм.

4.1. Ажиллаагүй байгаа механизмуудыг задлах, техникийн үйлчилгээ хийх ажлыг ахмадад мэдэгдэж, механик болон ахмадын ахлах туслахын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

4.2. Техникийн үйлчилгээг усан замын тээврийн хэрэгсэл эзэмшигч /өмчлөгч/-ийн баталсан техникийн үйлчилгээний журам, заавар болон техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл үйлдвэрлэгчийн зааварт нийцүүлэн хийнэ. Техникийн үйлчилгээ хийх давтамжийг эзэмшигч /өмчлөгч/ тогтооно.

4.3. Техникийн үйлчилгээ хийх ажлыг тогтоосон хугацаа, хэмжээгээр гүйцэтгэх үүрэг тухайн техник, тоног төхөөрөмж, хэрэгслийг хариуцаж буй багийн гишүүдэд ногдоно. Техникийн үйлчилгээгээр хийгдэж буй ажлын гүйцэтгэлд механик байнгын хяналт тавина.

4.4. Өдөр тутмын техникийн үйлчилгээг багийн гишүүд хийнэ. Усан замын тээврийн хэрэгслийн техник, тоног төхөөрөмж, хэрэгслийн төлөвлөгөөт, давтамжит техникийн үйлчилгээг үйлдвэрлэгчийн зааврын дагуу багийн гишүүд, эсвэл эргийн байгууллагын ажилтнууд хийнэ. Эргийн байгууллагын ажилтнуудын хийж буй механизмуудын техникийн үйлчилгээг тэдэнтэй байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэнэ.

4.5. Техникийн үйлчилгээ хийх явцад илрүүлсэн эвдрэл, гэмтлийг засварлана. Тухайн цаг мөчид техникийн хувьд засварлах боломжгүй, шинж чанараараа аюултай хор уршиг учруулахааргүй эвдрэл, гэмтэл байвал тухайн техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл хязгаарлалттай, түр ашиглахыг усан замын тээврийн улсын байцаагч зөвшөөрч болно. Ашиглалтын хязгаарын шинж чанар, зэргийг улсын байцаагч, усан замын тээврийн хэрэгсэл эзэмшигч /өмчлөгч/-ийн өргөдлөөр онцгойлон үзэж тодорхой хугацаагаар тогтооно.

4.6. Үндсэн бүх механизм, системүүдийг задлах, угсрехад зайлшгүй шаардлагатай тусгай түлхүүр багаж, хэрэгслээр хангасан байна. Нөөц сэлбэг хэрэгсэл, тусгай түлхүүр багаж, хэрэгслүүдийг бүрэн бүтэн, тэдгээрт зориулж тусгайлан бэлтгэсэн, хялбархан авч болох, ил харагдах, чанарын шаардлага хангасан газарт найдвартай бэхэлсэн байна.

## 5. Усан замын тээврийн хэрэгслийн сул зогсолт

5.1. Усан замын тээврийн хэрэгслийг ашиглахгүй байх үе сул зогсолт юм. Усан замын тээврийн хэрэгслийг хөвөлтийн үед болон хөвөлтийн улирал хооронд эзэмшигч /өмчлөгч/-ийн шийдвэрээр ашиглалтаас гаргаж сул зогсоно.

5.2. Усан замын тээврийн хэрэгслийг хөвөлтийн улиралд эзэмшигч /өмчлөгч/-ийн шийдвэрээр сул зогсоно. Энэ үед түүний техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, системийг ажиллуулахгүй /хүйтэн байдалд/-гээр эсвэл ажиллуулсан хэвээр нь ашиглалтаас гаргана.

5.3. Усан замын тээврийн хэрэгслийг өвлүүн сул зогсолтод тавихад бэлтгэх зохион байгуулалтын арга хэмжээ, түүнчлэн усан замын тээврийн хэрэгслийн зарим техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, системийг өвөлжилтэд бэлтгэх, хадгалах ажлууд болон тэдгээрийг биелүүлэх хугацааг эзэмшигч /өмчлөгч/ тогтооно.

5.4. Өвлүүн сул зогсолтын хугацаанд усан замын тээврийн хэрэгслийн техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, механизм, системийг хадгалахдаа тэдгээрийн техник-ашиглалтын зааварт заасны дагуу гүйцэтгэнэ.

5.5. Усан замын тээврийн хэрэгслийг өвөлжилтэд бэлтгэх, түүний болон түүн дээрх эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, механизм, системийг хадгалах, ослоос урьдчилан сэргийлэх аврах болон галын аюулаас урьдчилан сэргийлэх тоног төхөөрөмж, хэрэгслийн бэлэн байдлыг хангах ажлыг ахмадын удирдлагаар гүйцэтгэнэ.

5.6. Усан замын тээврийн хэрэгслийг удаан /хөвөлтийн улирал хоорондын хугацаанаас илүү/ хугацаагаар ашиглалтаас гаргах тохиолдолд усан замын тээврийн хэрэгсэл, түүний техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, механизм, системийн бүрэн бүтэн байдлыг бүхэлд нь хангахын тулд тэдгээрийн техник-ашиглалтын зааварт заасны дагуу тусгай нөөцөд хадгална. Усан замын тээврийн хэрэгслийг тусгай нөөцөд хадгалах ажил дууссаны дараа эзэмшигч /өмчлөгч/ акт үйлдэж, усан замын тээврийн хэрэгслийг тусгай нөөцөд хадгалсан тухай болон хадгалах хугацааг заасан тушаал гаргана.

5.7. Хөвөлтийн үед сул зогсолтод гаргасан усан замын тээврийн хэрэгслийн хамгаалалтыг багийн гишүүд эсвэл сул зогсолтын цэгийн ажилтнууд гэрээгээр гүйцэтгэнэ.

5.8. Хөвөлтийн болон хөвөлтийн улирал хооронд, эзэмшигч /өмчлөгч/ ба байгууллагын захиргаа хооронд байгуулсан гэрээний нөхцлийн дагуу усан замын тээврийн хэрэгслийг засварт эсвэл сул зогсолтод хүлээн авсан актад гарын үсэг зурсан үеэс усан замын тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, түүний бүх бүрэлдэхүүн хэсгүүдийн бүрэн бүтэн байдлын хариуцлагыг гэрээнд зааснаар тодорхойлно.

## 6. Усан замын тээврийн хэрэгслийн засвар

Засвар нь техникийн ашиглалтын нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд усан замын тээврийн хэрэгсэл, объект болон түүнийг бүрдүүлэгч хэсгүүдийн техник-ашиглалтын үзүүлэлтүүдийг тодорхой цаг хугацаанд сэргээх, хэвийн ажиллагаатай байлгах зорилгоор хийгддэг.

6.1. Усан замын тээврийн хэрэгслийн засварыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

6.1.1. урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт систем засвар – тогтоосон давтамжтай хийж буй цогц төлөвлөгөөт засварууд;

6.1.2. техникийн байдлаар – хүчин төгөлдөр үйлчилж буй тооцоолох болон элэгдэл, зэврэлт хэмжих аргуудаар тодорхойлсон усан замын тээврийн хэрэгслийн үндсэн бүрдүүлэгч хэсгүүдийн элэгдэл, зэврэлтийн байж болох хэм хэмжээний системээр.

6.2. Урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт систем засварыг усан замын тээврийн хэрэгслийн ашиглалтын бүх хугацааны туршид хийнэ.

6.3. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн байдал, ашиглагдах хугацаанаас хамааран урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт систем засварт дараах засварыг оруулдаг:

- урсгал;
- дундын;
- сэргээн босгох их /капитал/ засвар.

Дурдсан засваруудын хоорондох хугацаанд усан замын тээврийн хэрэгслийн техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, механизм, системийн техникийн үйлчилгээг тэдгээрийн ашиглалтын зааврын дагуу хийх ба шаардлагатай тохиолдолд баталгаат болон аваарийн засварыг хийнэ.

6.4. Урсгал засварыг усан замын тээврийн хэрэгслийн техник-ashiглалтын үзүүлэлтүүдийг өгөгдсөн хязгаарт байлгах, түргэн элэгддэг хэсгүүдийг сэргээх, солих зорилгоор хийдэг. Урсгал засварыг дундын болон сэргээн босгох капитал засваруудын хооронд хийнэ. Урсгал засвар хийх тодорхой хугацаа, давтамж болон хамрах хэмжээг усан замын тээврийн хэрэгслийнхээ бодит байдлыг тооцож, эзэмшигч /өмчлөгч/ тодорхойлно. Урсгал засварын дараа усан замын тээврийн хэрэгслийг ашиглалтад хүлээн авах дэг, дарааллыг эзэмшигч /өмчлөгч/ хяналтын байгууллагыг оролцуулан тогтооно.

6.5. Урсгал засварын хоорондох хугацааг баримталсан нөхцөлд дараагийн ээлжит дундын /их, капитал/ засвар хүртэл усан замын тээврийн хэрэгслийн ажиллагааг хангах, түүний тодорхой нэр төрлийн нэг хэсгийг сэргээх, солих замаар техник-ashiглалтын үзүүлэлтүүдийг нь өгөгдсөн утганд хүртэл сэргээх зорилгоор дундын засварыг хийнэ.

Дундын засварын үед усан замын тээврийн хэрэгслийн их биеийн байгууламжийн ялтас төмрийн уулзвар, зангилаа хэсгүүдийн гагнаас болон бүх техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, механизм, системд элэгдэл, гэмтэл, зэврэлт илрүүлэх үзлэг хийж, үзлэгийн дүнгээр усан замын тээврийн хэрэгслийн их биеийн байгууламжийн гадаргууны ялтас төмөр, техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, механизм, системийн эд ангийг солих эсвэл уулзвар, зангилааг сэргээнэ.

Усан замын тээврийн хэрэгслийн техникийн байдлаас хамаарч дундын засварыг хийх хугацааг өөрчилж болно.

Дундын засварыг хийж дууссаны дараа усан замын тээврийн хэрэгслийг ашиглалтад хүлээн авахдаа засвар гүйцэтгэгч, эзэмшигч /өмчлөгч/, хяналтын байгууллагыг оролцуулан комисс байгуулна.

6.6. Усан замын тээврийн хэрэгслийн үндсэн эд ангиудыг болон бусад аливаа эд ангийг солих буюу сэргээн засварлаж, мөн зөв зүйтэй өөрчлөлт, шинэчлэлийн ажлыг гүйцэтгэн түүний техник-ashiглалтын үзүүлэлтүүдийг баригдаж байх үеийнх нь тоон утгад хүргэх зорилгоор иж бүрэн сэргээн засварлах их /капитал/ засварыг хийнэ. Усан замын тээврийн хэрэгслийн тодорхой хэсгүүд /уулзвар, зангилаа/, гол ба туслах хөдөлгүүрүүд, түүнчлэн туслах механизмууд болон техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, системүүдийн капитал засварын хугацаа болсон эсэхээс үл хамааран ашиглалтын нөөц нь дууссан, эсвэл тэдгээрийн техникийн байдал нь капитал засвар хийхийг шаардаж буй тохиолдолд их /капитал/ засвар хийнэ. Иж бүрэн сэргээн засварлах их /капитал/ засварын дараа усан замын тээврийн хэрэгслийг ашиглалтад хүлээн авахдаа засвар хийсэн байгууллага, эзэмшигч /өмчлөгч/, хяналтын байгууллагыг оролцуулан комисс байгуулна.

6.7. Дундын болон сэргээн босгох их /капитал/ засварыг хийхдээ усан замын тээврийн хэрэгслийг эрэгт гаргаж, тусгайлан зассан засварын зогсоол /док/, налуу тавцан /эсвэл бусад аргаар их биеийн байгууламжийн усан дор оршдог ёроолыг ил гарган/ дээр хийнэ. Засварын явцад эвдрэл, гэмтэл, зэврэлтийг тогтоож, их биеийн байгууламжийг зэврэлт, элдэв замаг, ургамалын ургалт, бактерын наалдацаас хамгаалах хамгаалалтыг сэргээн, их биеийн усан дор оршдог ёроол, жолооны хөдөлгөгч иж бүрдэл, ёроолын ханын арматур болон усан замын тээврийн хэрэгслийн ёроолын бусад хэсэгт илрүүлсэн эвдрэл, гэмтлийг засварлаж, зэврэлтээс хамгаална.

6.8. Осол, аваар гарсан буюу тээврийн бусад зөрчлийн улмаас бий болсон эвдрэл, гэмтлийг засах, усан замын тээврийн хэрэгслийн техник-ашиглалтын үзүүлэлтийг сэргээх зорилгоор осол, аваарийн засварыг хийнэ. Осол, аваарийн засварт хүчин төгөлдөр үйлчилж буй заавруудад нийцүүлэн акт үйлдэнэ. Засварын өмнө ба хойно усан замын тээврийн хэрэгслийг техникийн хяналтын ээлжит бус үзлэгт оруулна. Зарим тохиолдолд хөвөлтийн аюулгүй байдлыг хангахдаа Техникийн хяналтын байгууллагатай зөвшилцэж, засварын ажил хийхийг хэсэгчлэн буюу ээлжит төлөвлөгөөт засвар хүртэл бүрэн хойшуулж болно.

6.9. Усан замын тээврийн хэрэгслийг барьж байгуулсны дараа болон үйлдвэрлэгчээс хийсэн засварын дараа, түүний ашиглалтын явцад баталгаат хугацаанд /баталгаагаар хүлээсэн үүргийн дагуу/, техник – ашиглалтын зөрчил гаргаагүй байхад барилга байгууламж /засварт/ -д илэрсэн гажилт, зогсолт, эвдрэл, гэмтлийг засвар хийсэн газар, эсвэл усан замын тээврийн хэрэгслийг үйлдвэрлэгч өөрийн хөрөнгөөр засварлана. Баталгаат засварыг хийх үндэслэл нь үйлдвэрлэгчид болон засварын газарт эзэмшигч /өмчлөгч/-ийн үзүүлэх акт болно.

6.10. Усан замын тээврийн хэрэгслийг урсгал, дундын, сэргээн босгох их /капитал/ засвараас ашиглалтын бэлэн байдалд хүлээн авсан актууд болон засвар гүйцэтгэсэн жагсаалт нь түүнийг ашиглалтын бэлэн байдалд байгааг баталсан баримтууд болно.

6.11. Усан замын тээврийн хэрэгслийг техникийн байдал /элэгдэл хороодлын байж болох хэм хэмжээ/ - аар нь засварлах үед эзэмшигч /өмчлөгч/ усан замын тээврийн хэрэгслийнхээ үндсэн хэсгүүдийн техникийн байдалд байнгын хяналт тавина. Усан замын тээврийн хэрэгслийн элэгдэл хороодлын байж болох хэм хэмжээ нь хэтэрсэн үндсэн хэсгүүдийн засварыг эзэмшигч /өмчлөгч/ шаардлагатай хэмжээгээр зохион байгуулах ба техникийн хяналтын байгууллагын зааварын дагуу шинээр солино.

6.12. Засварын байгууллагатай эзэмшигч /өмчлөгч/-ийн байгуулсан гэрээний дагуу усан замын тээврийн хэрэгслийг засварт оруулна. Гэрээнд дараах зүйлийг тусгана.

- тооцооны нөхцөл, өртөг;
- эхлэх, дуусах хугацаа;
- засварын байгууллагын гүйцэтгэх ажлын хэмжээ;
- усан замын тээврийн хэрэгслийг засварт бэлтгэх, хүлээн авах болон засвараас гаргах, хүлээн авах нөхцөл;
- техникийн хяналтын байгууллагын оролцоо;
- баталгаагаар хүлээсэн үүрэг;
- засварын байгууллагад өгсөн ажлын жагсаалтад тусгагдаагүй засварын ажлыг эзэмшигч /өмчлөгч/-ийн татан оролцуулж буй багийн гишүүдийн хүчээр болон бусад байгууллагаар гүйцэтгүүлэх нөхцөл, хэмжээ;
- усан замын тээврийн хэрэгслээс салгасан эд анги, тоног төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцах;
- талуудын зөвшилцсөнөөр бусад нөхцлүүд.

6.13. Төлөвлөж буй засварын ажлын жагсаалтыг бүрдүүлэх анхан шатны материалууд:

- хяналтын байгууллагын шаардлага, удирдамж заавар, актууд;

- элэгдэл, хорогдлын байж болох хэм хэмжээ;
- ашиглалтын явц дахь ажиглалт, үзлэг ба засварын өмнөх эвдрэл, гэмтэл илрүүлэх үзлэгийн үр дүн.

6.14. Усан замын тээврийн хэрэгслээ засварт оруулахын өмнө эзэмшигч /өмчлөгч/ дараах үүрэгтэй:

6.14.1. шаардлагатай тохиолдолд санал болгосон ажлын онцлог, шинж чанар, хэмжээг болон засварын баримт бичгүүдийг нарийвчлах зорилгоор усан замын тээврийн хэрэгсэлд үзлэг хийх боломжийг засварын байгууллагад олгоно;

6.14.2. санал болгосон засварын ажлын жагсаалтыг хяналтын байгууллагын дүрэмд нийцүүлэх талаар уг байгууллагатай зөвшилцөх;

6.14.3. санал болгосон засварын ажлыг хийхэд зайлшгүй шаардлагатай, усан замын тээврийн хэрэгслийн зохион бүтээгдсэн болон техникийн баримт бичгүүдийг засварын байгууллагад шилжүүлэн өгөх;

6.14.4. засварын хугацаанд усан замын тээврийн хэрэгсэл дээр /гэрээний дагуу/ үлдээх багийн гишүүдийн too, бүрэлдэхүүнийг батлах;

6.15. Усан замын тээврийн хэрэгслийг засварт бэлтгэх ажлыг зохион байгуулах үүрэг усан замын тээврийн хэрэгслийн ахмад, механикт ногдоно.

6.16. Бэлтгэсэн усан замын тээврийн хэрэгслээ засуулахаар засварын байгууллагад хүлээлгэн өгөхдөө акт үйлдэх ба актад гарын үсэг зурсан өдрөөс засвар эхэлсэн гэж үзнэ. Засварын явцад засагдаж буй усан замын тээврийн хэрэгсэлд шаардлагатай ажлын зураг, технологийн горим, эсгүүрийн хэрэгцээ гарсан бол тэдгээрийг засч буй байгууллага боловсруулна.

6.17. Дундын болон сэргээн босгох их /капитал/ засварыг техникийн хяналтын байгууллага болон эзэмшигч /өмчлөгч/-ийн хяналтын дор хийнэ. Засвар хийхэд ашиглаж буй материалууд, механизм, эд анги, их биеийн байгууламжийн араг ясны технологийн, техникийн болон зохион бүтээсэн баримт бичгүүдийг эзэмшигч /өмчлөгч/-тэй зөвшилцөх бөгөөд шаардлагатай бол хяналтын байгууллагаас зөвшөөрөл авна. Усан замын тээврийн хэрэгсэл дээр суурилуулж буй хяналтын байгууллагын хяналтад байх ёстой механизм, тоног төхөөрөмж болон эд анги, материалууд зохих ёсны гэрчилгээтэй байна.

6.18. Усан замын тээврийн хэрэгслийг засварт оруулахаар байршуулсны дараа эзэмшигч /өмчлөгч/, засварын байгууллагын төлөөлөгчид түүнд үзлэг хийх ба түүнийг өргөж засварын дэвжээн дээр болон засварын налуу тавцан дээр байршуулсны дараа их биеийн байгууламж, жолоодлогын залуурын иж бүрдэл, их биеийн гаднахь арматурын гэмтэл, эвдрэл, зэврэлтийг тодорхойлж засварын ажлын хэмжээ далайц, засварын хугацааг нарийвчилна. Механизм, эд анги, зангилааны засварын шинж чанарыг нарийвчлан тодорхойлохын тулд засварын өмнөх туршилт хийх шаардлагатай бол эзэмшигч /өмчлөгч/ туршилтыг хийнэ.

6.19. Усан замын тээврийн хэрэгслийн ахмад, механик эсвэл эзэмшигч /өмчлөгч/-ийн бүрэн эрх олгосон этгээд засварын ажлын гүйцэтгэл, хугацааг хянах ба усан замын тээврийн хэрэгслийг засвараас гаргаж хүлээн авах ажилд оролцно.

6.20. Засварын байгууллагын гүйцэтгэсэн ажлын чанар, бүрэн дуусгасан байдал, хэрэглэсэн материалууд техникийн нөхцөл, стандартад нийцэж байгаа эсэх хариуцлагыг засварын байгууллага хүлээнэ.

6.21. Дундын ба сэргээн босгох их /капитал/ засварын дараах усан замын тээврийн хэрэгслийн туршилтыг засварын байгууллага эсвэл засварын төслийн зохиогч боловсруулсан хөтөлбөрийн дагуу эзэмшигч /өмчлөгч/, хяналтын байгууллагатай зөвшилцөн явуулна.

Туршилтын туршид усан замын тээврийн хэрэгсэл, түүний бүх техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, механизмийн үйлчилгээг багийн гишүүд хариуцан гүйцэтгэнэ. Туршилтын явцад усан замын тээврийн хэрэгслийн ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлэх гэмтэл, согогыг илрүүлсэн бол, тэдгээрийг засварласны дараа эзэмшигч /өмчлөгч/-ийн эсвэл хяналтын байгууллагын шаардлагаар дахин туршилт явуулна.

6.22. Усан замын тээврийн хэрэгслийг засварлаж байх хугацаанд түүний галын аюулгүй байдлыг хангах хариуцлагыг засварын гэрээгээр тодорхойлно.

Эзэмшигч /өмчлөгч/-ийн томилсон ахмад эсвэл бусад этгээд засварлагдаж буй усан замын тээврийн хэрэгслийн галын аюулгүй байдлыг хангах хяналтыг хийнэ.

6.23. Засвар дууссаны дараа:

6.23.1. засварын байгууллагад шилжүүлсэн бүх баримт бичгийг усан замын тээврийн хэрэгсэл дээр буцааж авчирна;

6.23.2. засварын байгууллага засвар хийсэн тайлан, баримт бичгийг болон хийж гүйцэтгэсэн ажлын үнэ өртгийг заасан засварын жагсаалтыг эзэмшигч /өмчлөгч/-ийн төлөөлөгчид шилжүүлэн өгнө.

6.24. Баталгаат хугацаанд илэрсэн засварын ажлыг чанаргүй хийж гүйцэтгэсэнтэй холбоотой эвдрэл, гэмтэлд акт үйлдэж, засвар хийсэн байгууллагад шилжүүлэн өгнө. Илэрсэн эвдрэл, гэмтлийг засварын байгууллага гэрээнд заасан хугацаанд засварлана.

## 7. Усан замын тээврийн хэрэгслийг ашиглалтад бэлтгэх

7.1. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журмын дагуу бүртгүүлж, ашиглалтын бэлэн байдлыг хангасан усан замын тээврийн хэрэгслийг ашиглалтад оруулна. Усан замын тээврийн хэрэгслийг ашиглалтад оруулахын өмнө эзэмшигч /өмчлөгч/-ийн баталсан багийн бүрэлдэхүүний жагсаалтын дагуу багийн гишүүдийг бүрдүүлнэ.

7.2. Усан замын тээврийн хэрэгслийг ашиглалтад оруулах бэлтгэлийг ахмадын ерөнхий удирдлагын дор хэрэгжүүлнэ. Ашиглалтад оруулах бэлтгэл ажлын шууд удирдлагыг ахмадын ахлах туслах, ахлах механик, механик өөрсдийн ажил үүргийн хуваарийн дагуу хэрэгжүүлнэ.

7.3. Усан замын тээврийн хэрэгслийн дээр суурилуулсан техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, механизм, түүний дотор холбоо дохио, радионавигацийн тоног төхөөрөмж, аккумуляторын батарей зэрэг тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулах бэлтгэл ажлын явцад тэдгээрийн ашиглалтын техникийн нөхцөлд нийцүүлэн ажлын горимд оруулна.

Ашиглалтад оруулахаар багийн гишүүдийн гүйцэтгэх усан замын тээврийн хэрэгсэл дээр суурилуулсан техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, механизм, түүний дотор холбоо дохио, радионавигацийн тоног төхөөрөмж, аккумуляторын батарей зэрэг тоног төхөөрөмжийн бэлтгэл ажил нь тэдгээрийн нарийвчилсан үзлэг, техникийн байдлыг шалгахаас эхлэх ба шаардлагатай бол хуваарилах эд ангиуд, залгах, ухраах төхөөрөмж, удирдлага хяналтын болон дохиолол хамгаалалтын хэрэгслийн тохиргоог хийж, зайлшгүй тохиолдолд туршилтын асаалт, залгалтыг хийж механизмуудыг эргэлдүүлж туршилт хийнэ.

Туршилтын асаалтыг удирдлагын бүх байр /цэг/-наас гүйцэтгэнэ.

7.4. Усан замын тээврийн хэрэгслийг ашиглалтад бэлтгэхдээ дараах механизмуудын бүрэн бүтэн байдал, ажиллагааны бэлэн байдалд онцгой анхаарна:

- жолоодлогын тоног төхөөрөмж;
- зангууны тоног төхөөрөмж;
- осол аваарийн дохионы хэрэгслүүд;
- цахилгааны болон гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж;
- аврах хэрэгслүүд;
- галын аюулаас сэргийлэх хэрэгслүүд;
- алсын зайны удирдлага;
- хатаах систем;
- экологийн тоног төхөөрөмж;

- ус үл нэвтрүүлэх болон галын аюулаас хамгаалах тагны түгжээ;
- аваарийн үед хэрэглэх эд хөрөнгө.

7.5. Усан замын тээврийн хэрэгслийг ашиглалтад бэлтгэхдээ дотоод тавилга, сэлбэг хэрэгсэл болон бусад зайлшгүй хангамжаар хангана.

## **8. Усан замын тээврийн хэрэгслийг түлш шатахуун, тос, усаар хангах**

8.1. Усан замын тээврийн хэрэгслийн эрчим хүч үүсгэгч тоног төхөөрөмжид ашиглаж буй түлш шатахуун, тос нь гадаад орчны янз бүрийн нөхцөлд, дизель хөдөлгүүр, уурын даралтат тоног төхөөрөмж, механизмуудын техникийн нөхцлөөр тогтоосон хэвийн үзүүлэлтээр нь найдвартай, үр ашигтай ажиллагааг хангаж байх ёстой.

8.2. Түлш шатахуун, тосыг битүүмжилсэн байдлаар усан замын тээврийн хэрэгсэл дээр хүлээн авна. Түлш шатахуунаар цэнэглэхдээ усан замын тээврийн хэрэгсэл эзэмшигч /өмчлөгч/-ийн баталсан цэнэглэх зааврын дагуу эсвэл түүний даалгаснаар ахмадын заавраар гүйцэтгэх ба түлш шатахуун, тос нь паспорт эсхүл гэрчилгээтэй байна. Эдгээр баримт бичигт түлш шатахуун, тосны марк ба үндсэн физик-химийн үзүүлэлтүүдийг заана.

8.3. Усан замын тээврийн хэрэгсэл дээр хүлээн авч буй түлш шатахуун, тосны багц бүрээс цэнэглэгч этгээд сорьц авч түлш шатахуун, тосны температурыг зааж лацдах бөгөөд сорьцыг тухайн багц түлш шатахуун, тосыг хэрэглэж дуусах бүх хугацааны туршид усан замын тээврийн хэрэгсэл дээр хадгална.

8.4. Хүлээн авах үедээ эсхүл хэрэглэх үед түлш шатахууны эсвэл тосны чанарт эргэлзээтэй шинж тэмдэг илэрсэн бол механик сорьц сонгон авч, хяналтын шинжилгээ хийлгэхээр лабраторид хүргүүлэх ба лабораторийн дүгнэлтийг үндэслэн цаашид хэрэглэх боломжтой эсэх, эсвэл нийлүүлэгчтэй заргалдах эсэх тухай шийдвэрийг гаргана.

8.5. Усан замын тээврийн хэрэгсэл дээр түлш шатахуун, тос хүлээн авах, хадгалах, зарцуулахад хяналт тавих болон зохих баримт бичгийг бүрдүүлэх ажлыг механик хариуцна. Түүхий нефть бүтээгдэхүүн хүлээн авах ажиллагааг ээлжинд гарч буй ахмадын туслахын шийдвэрээр гүйцэтгэнэ.

8.6. Түлш шатахуун, тосыг хүлээн авах үед асгарахаас урьдчилан сэргийлж усан замын тээврийн хэрэгсэл ба цэнэглэгч хоорондоо шууд холбогдсон байна.

8.7. Хөдөлгүүр, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг алдагдуулж болзошгүй механик хольц, усыг зайлзуулах зорилгоор усан замын тээврийн хэрэгслийн эрчим хүчний эх үүсвэрт хэрэглэх түлш шатахуун, тосыг зохих шүүлтэд оруулдаг.

8.8. Тослох материалыг цаг тухайд нь солих, ажиллаж буй механизм, системд тэдгээрийг хэмнэлттэй зарцуулахын тулд усан замын тээврийн хэрэгсэлд хэрэглэж буй тос, тослох материал, тусгай шингэний төлөв байдалд хяналт тавина. Усан замын тээврийн хэрэгслийн ажиллаж буй тосны чанарт механик, эргийн болон усан замын тээврийн хэрэгсэлд тоноглосон лабораторийн дүгнэлтээр хяналт тавина. Тосыг гологдолын үзүүлэлтээр нь солино.

8.9. Усан замын тээврийн хэрэгсэл дээрх түлш шатахуун, тосны зарцуулалтын тооцоог механик хийнэ. Түлш шатахуун, тосны зарцуулалтын тайлан тооцооны журам, загварыг усан замын тээврийн хэрэгслийн эзэмшигч /өмчлөгч/ тодорхойлно.

8.10. Эргийн зогсоолын байгууламжаас болон эрүүл ахуйн шаардлага хангасан бусад газраас усан замын тээврийн хэрэгсэл дээр ус нөөцөлж авна. Нуур, гол мөрөнд аялж буй усан замын тээврийн хэрэгсэл эрүүл ахуй, халдварт нян судлалын хяналтын байгууллагаас ашиглахыг зөвшөөрсөн ус цэвэршүүлэх төхөөрөмжтэй тохиолдолд нуур, гол, мөрний усыг цэвэршүүлж, ариутган хэрэглэж болно.

8.11. Ундны усны чанарт ахмадын ахлах туслах хяналт тавина. Ундны усан хангамжид тавих тодорхой давтамжит хяналтыг эрүүл ахуй, халдвэр нян судлалын байгууллага тавина.

## 9. Усан замын тээврийн хэрэгсэлд хийх хяналт, шалгалт

9.1. Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлыг хангах, хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, тээвэрлэж буй ачааны бүрэн бүтэн байдлыг хадгалах болон хүрээлэн буй усан орчинг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор усан замын тээврийн хэрэгсэлд Усан замын тээврийн тухай<sup>3</sup> тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу хяналт хийнэ.

9.1.1. Усан замын тээврийн хэрэгслийг ашиглах хугацаанд дараах хяналт, шалгалтыг хийнэ:

- техникийн;
- галын;
- эрүүл ахуй, халдвэр нян судлалын;
- хөдөлмөр хамгааллын;
- экологийн;
- холбоо, дохионы;
- усан замын хөвөлтийн аюулгүй байдлын.

9.1.2. Хяналт, шалгалтын дүгнэлтээр, үүнд бүрэн эрх олгогдсон байгууллагууд хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг нь заасан, тогтоосон загварын баримт бичгийг усан замын тээврийн хэрэгсэлд олгоно.

9.1.3. Усан замын тээврийн хэрэгсэл, түүний техник, тоног төхөөрөмж, хэрэгслийг үзлэгт цаг тухайд нь оруулахыг эзэмшигч /өмчлөгч/ хариуцна.

9.1.4. Усан замын тээврийн хэрэгслийн ахмад нь осол аваартай холбоотой болон усан орчныг бохирдуулсан тохиолдолд тусгай үзлэг хийлгэхээр хяналтын зохих байгууллагын байцаагчдыг дуудна. Усан замын тээврийн хэрэгсэл дээр байцаагч хүрэлцэн ирэх боломжгүй тохиолдолд эзэмшигч /өмчлөгч/, ахмадын шийдвэрээр болсон явдлыг мөрдөн шалгалтын дүгнэлт, акт, материалыг хяналтын зохих байгууллагад танилцуулна.

9.1.5. Усан замын тээврийн хэрэгсэл, түүний техник, тоног төхөөрөмж, хэрэгслийг хяналтын байгууллагын байцаагчид үзлэг хийх үедээ усан замын тээврийн хэрэгслийн ахмадаас үүнд эрх олгосон этгээдийг байлцуулна.

9.1.6. Хяналтын байгууллагын шаардлагыг усан замын тээврийн хэрэгслийн эзэмшигч /өмчлөгч/ хүлээн зөвшөөрөхгүй байгаа бол дээд байгууллагад нь эсвэл арбитрын шүүхэд хандана.

## 9.2. Техникийн хяналт

9.2.1. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтыг Усан замын тээврийн<sup>4</sup> тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хэрэгжүүлэх ба хангалттай гэж үзвэл зохих гэрчилгээ олгох бөгөөд гэрчилгээний үйлчлэх хугацааг сунгах буюу цуцална.

## 9.3. Галын аюулгүй байдалд тавих хяналт

9.3.1. Усан замын тээврийн хэрэгслийг галаас хамгаалах тоног төхөөрөмж хэрэгслээр бүрэн тоноглогдсон эсэх, түүний гал унтраах систем, галын дохиолол, галын аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмжүүд үндэсний хууль тогтоомжийн

<sup>3</sup> Усан замын тээврийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2017 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Усан замын тээврийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2017 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

шаардлагыг хангаж буй эсэхэд тавих хяналтыг Галын аюулгүй байдлын<sup>5</sup> тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлэх ба хангалттай гэж үзвэл зохих гэрчилгээ олгох бөгөөд гэрчилгээний үйлчлэх хугацааг сунгах буюу цуцална. Үзлэг шалгалтын үр дүн болон зайлшгүй шаардлагатай мэдээллийг усан замын тээврийн хэрэгслийн үзлэгийн нэгдсэн дэвтэрт бичнэ.

9.3.2. Усан замын тээврийн хэрэгслийн аялалын хугацаанд галын аюулгүй байдлыг хангах дүрэм, журмын биелэлтэд хяналт тавих, галын аюулгүй байдлыг шалгах ажиллагааг ахмад хэрэгжүүлнэ.

#### **9.4. Эрүүл ахуй, ариун цэвэр, халдварт нян судлалын хяналт, шалгалт**

9.4.1. Усан замын тээврийн хэрэгсэл, түүний техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, механизм, системийн эрүүл ахуй, ариун цэврийн ерөнхий байдал болон эрүүл ахуй, ариун цэвэр, халдварт нян судлалын хэм хэмжээ, дүрэм, журмыг мөрдөж буй эсэхийг МХЕГ-ын эрүүл ахуйн улсын байцаагч шалгаж хяналт тавих ба хангалттай гэж үзсэн тохиолдолд гэрчилгээ олгох бөгөөд гэрчилгээний үйлчлэх хугацааг сунгах буюу цуцална.

#### **9.5. Хөдөлмөр хамгааллын шалгалт, хяналт**

9.5.1. Усан замын тээврийн хэрэгсэл дээр хөдөлмөр хамгааллын хэм хэмжээ, дүрэм журам мөрдөгдөж буй эсэхийг шалгах, хянах ажлыг МХЕГ-ын хөдөлмөр хамгааллын улсын байцаагч хэрэгжүүлнэ. Мөн усан замын тээврийн ажилтнуудын үйлдвэрчний эвлэлийн байцаагч хэрэгжүүлнэ. Үзлэг шалгалтын үр дүн болон зайлшгүй шаардлагатай мэдээллийг усан замын тээврийн хэрэгслийн үзлэгийн нэгдсэн дэвтэрт бичнэ.

#### **9.6. Экологийн шалгалт, хяналт**

9.6.1. Хүрээлэн буй усан орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх талаар усан замын тээврийн хэрэгсэл, түүний механизм, системд үндэсний хууль тогтоомж, дүрэм журам, хэм хэмжээгээр тавигддаг шаардлагыг мөрдөж буй эсэх техникийн шалгалт, хяналтыг МХЕГ-ын төв орон нутгийн байгаль орчны улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

9.6.2. Усан замын тээврийн хэрэгслийн ашиглалтын үед экологийн аюулгүй байдлыг хангаж буй эсэх шалгалт, хяналтыг орон нутгийн захиргааны байгууллагын байгаль орчны байцаагчид хэрэгжүүлнэ.

9.6.3. Экологийн аюулгүй байдлыг хангах, усан замын тээврийн хэрэгсэл дээрээс аж ахуйн болон нефть агуулсан ус, хогоор болон хүмүүс, усны биологийн нөөцөд хор хохирол учруулах бусад хог бодисоор бохирдуулахаас урьдчилан сэргийлэх үүргийг эзэмшигч /өмчлөгч/ хэрэгжүүлнэ.

#### **9.7. Холбоо харилцааны шалгалт, хяналт**

9.7.1. Усан замын тээврийн хэрэгслийн радио холбоог ашиглах эрхийг харилцаа холбооны зохицуулах хорооноос авна. Техникийн үзлэг хийсний үндсэн дээр усан замын тээврийн хэрэгсэлд радио холбоо ашиглах зөвшөөрөл олгоно.

#### **9.8. Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын хяналт, шалгалт**

<sup>5</sup> Галын аюулгүй байдлын тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2015 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

9.8.1. Усан замын тээврийн<sup>6</sup> тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын хяналт, шалгалтыг усан замын тээврийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

9.8.2. Усан замын тээврийн улсын байцаагч нь усан замын тээврийн хэрэгслийн жолооч, эзэмшигч /өмчлөгч/, багийн гишүүд усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм, журам, стандарт, бусад хэм хэмжээ тогтоосон баримт бичгийн шаардлагыг мөрдөж буй эсэхийг шалгаж, хяналт тавина.

9.8.3. Үзлэг шалгалтын үр дүн болон зайлшгүй шаардлагатай мэдээллийг усан замын тээврийн хэрэгслийн үзлэгийн нэгдсэн дэвтэрт бичнэ.

9.9. Усан замын тээврийн хэрэгсэл эзэмшигч /өмчлөгч/-ийн зүгээс хийх шалгалт, хяналт

9.9.1. Усан замын тээврийн хэрэгсэл эзэмшигч /өмчлөгч/ нь тээврийн хэрэгслийнхээ техникийн байдалд болон хууль, дүрэм, журам, зааврын мөрдөлтөд хяналт тавина. Хяналт хийх давтамж, дэгийг тогтооно.

9.9.2. Усан замын тээврийн хэрэгсэл эзэмшигч /өмчлөгч/ нь улсын байцаагчдаас бүрдсэн тусгай комисс томилох замаар усан замын тээврийн хэрэгслийн техникийн байдлын хяналтыг хэрэгжүүлж болно. Байцаагчдын үзлэг шалгалт, хяналтаар усан замын тээврийн хэрэгслийг техникийн хувьд бүрэн бүтэн, өнгө үзэмжтэй байлгах талаар хийсэн багийн гишүүдийн ажлыг мөн үнэлнэ.

9.9.3. Байцаагчдын үзлэг шалгалт, хяналт хийх дэг, давтамж, хамрах хүрээ, комиссийн бүрэлдэхүүнийг усан замын тээврийн хэрэгсэл эзэмшигч /өмчлөгч/ батална.

## 10. Баримт бичгийн бүрдэл

10.1. Усан замын тээврийн хэрэгсэл нэг бүр, түүний зориулалт, аялах бүс, ашиглалтыг тогтоосон, зохих ёсоор бүрдүүлсэн, зайлшгүй шаардлагатай баримт бичигтэй байна.

10.2. Усан замын тээврийн хэрэгслийн зориулалт, хурд, өрөө тасалгаа, агуулах савны зориулалт, эсхүл байгууламж, дотоод засал, эсвэл их бие, жолоодлогын бүхээг, дээд тавцангийн гаднахь ус зайлцуулах нүх цооног, хаалт өөрчлөгдсөн болон салхинд туугдах, жингийн үзүүлэлтүүдийн өөрчлөлттэй холбоотой бүх тохиолдлуудад техникийн баримт бичгүүдэд өөрчлөлт оруулна.

Өөрчлөлтийг усан замын тээврийн хэрэгсэлд хийсэн бодит өөрчлөлтүүд болон туршилтын үзүүлэлтүүдэд нийцүүлэн оруулна. Усан замын тээврийн хэрэгслийн эзэмшигч /өмчлөгч/ тээврийн хэрэгслээ шаардлагатай баримт бичгүүдээр хангаж, тэдгээрт цаг тухайд нь өөрчлөлт оруулна.

10.3. Усан замын тээврийн хэрэгслийн баримт бичиг дараах баримт бичгүүдээс бүрдэнэ:

- тээврийн хэрэгслийн баримт бичгүүд;
- үйлдвэрлэгдсэн /баригдсан/ баримт бичгүүд;
- зохион байгуулалт – захирамжилсан баримт бичгүүд;
- хангамжийн баримт бичгүүд;
- эрх зүй- хэм хэмжээ тогтоосон баримт бичгүүд;
- норм, нормативууд;
- тайлан тооцооны баримт бичгүүд.

## 10.4. Усан замын тээврийн хэрэгсэл дээр байлгах үндсэн баримт бичгүүдийн жагсаалт

<sup>6</sup> Усан замын тээврийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2017 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

- 10.4.1. Усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх /эзэмших/ эрхийн гэрчилгээ;
- 10.4.2. Усан замын тээврийн хэрэгслийн хөвөх бүс /ангилал/-ийг заасан эсвэл Ангилалын гэрчилгээг хавсаргасан хөвөлтөд тохирсны гэрчилгээ;
- 10.4.3. Монгол Улсын далбаа мандуулан хөвөх эрхийн гэрчилгээ;
- 10.4.4. Усан замын тээврийн хэрэгслийн ахмадын үйлдсэн багийн гишүүдийн жагсаалт;
- 10.4.5. Усан замын тээврийн хэрэгслийн ээлжийн ажиллагааны болон хөдөлгүүрийн ажиллагааг тэмдэглэх дэвтэр;
- 10.4.6. Усан замын тээврийн хэрэгслийн эрүүл ахуйн гэрчилгээ;
- 10.4.7. Усан замын тээврийн хэрэгслийн үзлэг, хяналтын тэмдэглэлийн ном;
- 10.4.8. Хүрээлэн буй орчныг усан замын тээврийн хэрэгслээс шатах тослох материал, ахуйн бохир ус, хог хаягдлаар бохирдуулахаас урьдчилан сэргийлэх тухай гэрчилгээ;
- 10.4.9. Усан замын тээврийн хэрэгслийн радио холбоо ашиглах эрхийн зөвшөөрөл;
- 10.4.10. Усан замын тээврийн хэрэгслийн багийн гишүүдийн доод хязгаарыг тогтоосон гэрчилгээ.

Усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх /эзэмших/ эрхийн гэрчилгээнээс бусад бүх баримт бичгийг усан замын тээврийн хэрэгсэл дээр эх хувиар нь хадгална. Усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх /эзэмших/ эрхийн гэрчилгээний хуулбарыг түүнийг олгосон байгууллага эсвэл нотариатаар баталгаажуулсан байна.

## **10.5. Үйлдвэрлэгдсэн /баригдсан/ баримт бичгүүд**

10.5.1. Үйлдвэрлэгдсэн /баригдсан/ баримт бичгүүдэд зохион бүтээсэн, техникийн баримтууд, материалын болон техник, тоног төхөөрөмж, хэрэгслийн гэрчилгээнүүд, усан замын тээврийн хэрэгслийн техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, механизмын паспорт, тэдгээрийн техник-ашиглалтын үйлдвэрлэгчээс олгосон заавар, түүнчлэн усан замын тээврийн хэрэгслийг барьж ашиглалтад оруулсны дараах туршилтын хүлээн авсан-өгсөн үзүүлэлтүүд болон хазайлтын өнцгийн туршилтын тэмдэглэл, акт орно.

10.5.2. Үйлдвэрлэгдсэн /баригдсан/ баримт бичгийн нэг иж бүрдлийг усан замын тээврийн хэрэгсэл дээр хадгална. Хяналтын байгууллагатай зөвшилцэн эзэмшигч /өмчлөгч/-ийн шийдвэрээр зарим баримт бичгийн хуулбарыг хадгална. Хоёр дахь иж бүрдлийг усан замын тээврийн хэрэгслийн эзэмшигч /өмчлөгч/ хадгална. Усан замын тээврийн хэрэгсэл дээр хадгалж буй үйлдвэрлэгдсэн /баригдсан/ баримт бичгийн тоо хэмжээг хяналтын байгууллагатай зөвшилцэн эзэмшигч /өмчлөгч/ тодорхойлно.

## **10.6. Зохион байгуулалтын болон захирамжилсан баримт бичгүүд**

10.6.1. Зохион байгуулалтын болон захирамжилсан баримт бичгүүдийг эзэмшигч /өмчлөгч/-өөс тогтоосон загвар, too хэмжээгээр хөтөлнө. Энэхүү баримт бичгүүдэд тушаал шийдвэрийн хавтасууд, хүлээн авсан-өгсөн актууд, ээлжийн ажиллагааны хуваарь, түгшүүрийн дохиогоор ажиллах ба хариуцах ажил үүргийн хуваарь зэрэг усан замын тээврийн хэрэгслийн өдөр тутмын техник - ашиглалтын зохион байгуулалтыг агуулсан бусад баримт бичгүүд орно.

10.6.2. Зохион байгуулалтын баримт бичгүүдийг хөтлөх дэгийг баримт бичиг тус бүрт хавсаргасан зааврын дагуу тодорхойлно.

## **10.7. Хангалтын баримт бичгүүд**

10.7.1. Хангалтын баримт бичгүүдэд усан замын тээврийн хэрэгслийн байгууламж, техник тоног төхөөрөмж, хэрэгсэл, систем, механизмын ажиллагааг туршсан болон шалгасан баримт бичгүүд, зураг төсөл, схем, техникийн нөхцөл, тодорхойлолт, техникийн үзлэг, хяналтын актууд, засварын баримт бичгүүд орно.

10.7.2. Усан замын тээврийн хэрэгсэл дээр байх хангалтын баримт бичгүүдийн иж бүрдлийг хяналтын байгууллага ба эзэмшигч /өмчлөгч/ тогтооно. Хангалтын баримт бичгүүдийг усан замын тээврийн хэрэгсэл дээр хадгалах, ашиглах дэгийг ахмад, механиктай хамтран тогтооно.

## **10.8. Эрх зүйн хэм хэмжээний баримт бичгүүд**

10.8.1. Эрх зүйн хэм хэмжээний баримт бичгүүдэд үндэсний болон олон улсын хэм хэмжээ тогтоосон актууд, усан замын тээврийн хэрэгслийн техник – ашиглалтыг зохион байгуулах үндсэн зорилго, үүргийг тодорхойлсон захирамжилсан агуулгатай баримт бичгүүд, хяналтын байгууллагын дүрэм ба гарын авлага, салбарын нормативууд орно.

10.8.2. Эрх зүйн хэм хэмжээний иж бүрэн баримт бичгийг усан замын тээврийн хэрэгсэл дээр ахмад, механик хадгална. Усан замын тээврийн хэрэгсэл дээр хадгалагдах эрх зүйн хэм хэмжээний баримт бичгийн жагсаалтыг эзэмшигч /өмчлөгч/ хяналтын байгууллагатай зөвшилцөн тодорхойлно.

## **10.9. Норм, нормативууд**

10.9.1. Норм, нормативуудыг усан замын тээврийн хэрэгслийн техник тоног төхөөрөмж, хэрэгсэл, систем, механизмийг үйлдвэрлэгч үйлдвэр болон хяналт, шалгалтын байгууллага, эзэмшигч /өмчлөгч/-д тогтооно. Эзэмшигч /өмчлөгч/ нь усан замын тээврийн хэрэгслийг норм, нормативаар хангана.

## **10.10. Тайлан тооцооны баримт бичгүүд**

10.10.1. Усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын талаарх тайлан тооцооны баримт бичгүүдийг хяналт, шалгалтын байгууллага ба эзэмшигч /өмчлөгч/-ийн тогтоосон загвар, тоо хэмжээгээр хөтөлнө.

10.10.2. Техник ашиглалтын тайлангийн баримт бичгүүдэд усан замын тээврийн хэрэгслийн болон усан замын тээврийн хэрэгслийн техник тоног төхөөрөмж, хэрэгсэл, систем, механизмийн техник-ашиглалтын талаар болон техник ашиглалтын явцад зарцуулсан нөөцийн талаарх мэдээлэл агуулагдана. Тайлагнах дэгийг усан замын тээврийн хэрэгслийн эзэмшигч /өмчлөгч/ тодорхойлно.

10.10.3. Техник ашиглалтын анхан шатны тооцооны үндсэн баримт бичгүүдэд усан замын тээврийн хэрэгслийн ээлжийн ажиллагааны болон хөдөлгүүрийн тэмдэглэлийн дэвтэр, радио холбооны тэмдэглэлийн дэвтэр, усан замын тээврийн хэрэгслийн техник тоног төхөөрөмж, хэрэгсэл, систем, механизмд техникийн үйлчилгээ хийх төлөвлөгөө – график, материал техникийн хангарт, нөөц эд анги, хэрэгслийн тооцооны дэвтэр зэрэг баримт бичгүүд орно.

## **10.11. Усан замын тээврийн хэрэгслийн нэмэлт баримт бичгүүд**

10.11.1. Бүртгэлийн байгууллагаас олгосон гэрчилгээ, актууд;

10.11.2. Зорчигч тээвэрлэх гэрчилгээ /зорчигч тээврийн усан замын тээврийн хэрэгсэл/;

10.11.3. Нэг удаагийн аялалын гэрчилгээ;

10.11.4. Усан замын тээврийн хэрэгслийн төлөвлөгөөт бус үзлэгийн акт;

10.11.5. Усан замын тээврийн хэрэгслийн жил бүрийн үзлэгийн акт;

10.11.6. Усан замын тээврийн хэрэгслийн ээлжит үзлэгийн акт;

- 10.11.7. Усан замын тээврийн хэрэгслийн их биеийн ээлжит үзлэгийн акт;
- 10.11.8. Усан замын тээврийн хэрэгслийн механизмын ээлжит үзлэгийн акт;
- 10.11.9. Усан замын тээврийн хэрэгслийн цахилгаан тоног төхөөрөмж, хэрэгслийн ээлжит үзлэгийн акт;
- 10.11.10. Хөвөх бүс буюу ангилал тогтоосон үзлэгийн акт;
- 10.11.11. Засварын модон тавцан, налуу гулсуурт байгаа усан замын тээврийн хэрэгслийн үзлэгийн акт;
- 10.11.12. Усан замын тээврийн хэрэгслийн ангилалын үзлэгийн акт;
- 10.11.13. Уурын тогооны гидравликийн туршилтын дотоод үзлэгийн акт;
- 10.11.14. Даралтат хоолойнуудын гидравликийн туршилтын дотоод үзлэгийн акт;
- 10.11.15. Хөргөч тоног төхөөрөмж, хэрэгсэл, системийн үзлэгийн акт;
- 10.11.16. Өргөгч тоног төхөөрөмж, хэрэгсэл, механизмын үзлэгийн акт;
- 10.11.17. Усан замын тээврийн хэрэгслийн эд анги, материалын гэрчилгээ;
- 10.11.18. Дизель хөдөлгүүрийн гэрчилгээ;
- 10.11.19. Их засварт орсон дизель хөдөлгүүрийн гэрчилгээ;
- 10.11.20. Усан замын тээврийн хэрэгслийн тэнцвэр, тогтворжилт ба үл живэх чанарын мэдээлэл;
- 10.11.21. Усан замын ачаа тээврийн хэрэгслийг ачаалах, тэнцвэржүүлэх заавар;
- 10.11.22. Усан замын тээврийн хэрэгслийг хангах /цэнэглэх/ заавар;
- 10.11.23. Нефть агуулсан болон ахуйн бохир ус, хог, хадгалан аялах хоногийн тооцоо;
- 10.11.24. Тэнцвэрт байдлаа хадгалах ажиллагааг удирдах, хянах гарын авлага;
- 10.11.25. Нефть агуулсан ба ахуйн бохир усыг гадагш зайлзуулах шахуургын системийн болон бусад нээлхийг лацдах схем.

## **10.12. Бусад баримт бичгүүд**

- 10.12.1. Түгшүүрийн дохиогоор ажиллах хуваарь;
- 10.12.2. Ээлжийн ажиллагааны хуваарь;
- 10.12.3. Багийн гишүүдийн ажиллах дэг баталсан эзэмшигч /өмчлөгч/-ийн тушаал;
- 10.12.4. Цаг уурын төлөв байдал, замын мэдээллийг тэмдэглэсэн тэмдэглэлийн дэвтэр;
- 10.12.5. Радио холбооны тэмдэглэл;
- 10.12.6. Усан замын тээврийн хэрэгслийг ачаалах-буулгах заавар;
- 10.12.7. Радио холбоо ашиглах заавар;
- 10.12.8. Соронзон луужингийн гажилтын өнцгийн хүснэгт;
- 10.12.9. Усан замын тээврийн хэрэгслийн тэнцвэр, тогвортой байдлын ахмадад зориулсан мэдээлэл;
- 10.12.10. Усан замын тээврийн хэрэгслийн маневрлах элементүүдийн хүснэгт;
- 10.12.11. Радио холбооны дамжуулагч системийн сүүдэрлэгдэх схем;

## **11. Усан замын тээврийн хэрэгслийг ашиглалтаас гаргах /хасах/**

- 11.1. Усан замын тээврийн хэрэгслийн ашиглалтын тогтоосон хугацаа дууссан, эсхүл моралийн болон физик элэгдэлд орсны улмаас түүнийг цаашид ашиглах боломжгүй болсон, эсхүл түүнийг сэргээн засварлах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй бол эзэмшигч /өмчлөгч/ нь усан замын тээврийн хэрэгслийг ашиглалтаас гаргана. Усан замын тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацааг

захиалагч –эзэмшигч /өмчлөгч/-ийн тавьсан нөхцлийг үндэслэн төсөл зохион бүтээх үедээ тодорхойлно.

11.2. Ашиглалтаас гаргахаар төлөвлөж буй усан замын тээврийн хэрэгслийг эзэмшигч /өмчлөгч/-ийн тушаалаар ажлаас чөлөөлнө. Эзэмшигч /өмчлөгч/-ийн тушаалаар хяналтын байцаагчийг оролцуулсан ажлын хэсэг байгуулах ба ажлын хэсэг ашиглалтаас гаргах баримт бичгийг бүрдүүлэх үедэх усан замын тээврийн хэрэгслийн техникийн байдлыг үзэж шалгасан акт үйлдэнэ. Техникийн хяналтын үзлэг шалгалт хийж дүгнэлт гаргах боломжгүй сураггүй алга болсон, живсэн усан замын тээврийн хэрэгсэлд ажлын хэсэг ашиглалтаас гаргах баримтыг үйлдэнэ.

11.3. Хийж гүйцэтгэсэн үзлэгийг үндэслэн ажлын хэсэг усан замын тээврийн хэрэгслийн техникийн байдлын талаар дүгнэлт гаргах ба түүнийг болон түүний зарим хэсгийг цаашид ашиглаж болох тухай санал гаргана. Ажлын хэсгийн ажлын үр дүнг акт үйлдэж баталгаажуулна.

11.4. Ажлын хэсгийн техникийн актад хяналтын байгууллагын үзлэгийн актыг хавсаргасан байна.

11.5. Усан замын тээврийн хэрэгслийг ашиглалтаас гаргахад үйлдэх үндсэн баримт бичгүүд. Үүнд:

11.5.1. Хөвж буй болон эрэгт байгаа усан замын тээврийн хэрэгслийн хувьд ажлын хэсгийн акт, бүртгэлийн баримт бичиг, эзэмшигч /өмчлөгч/-ийн шийдвэр;

11.5.2. Живсэн усан замын тээврийн хэрэгслийн хувьд түүнийг дээш нь гаргаж, сэргээн засварлах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй гэдгийг баталсан эзэмшигч /өмчлөгч/-ийн дүгнэлтийг хавсаргасан, гүний шумбагчийн акт. Живсэн усан замын тээврийн хэрэгсэл байгаль орчинд хор хохирол учруулахуйц, эсвэл усан замын хөвөлтийн аюулгүй байдалд аюул учруулахаар байвал түүний эзэмшигч /өмчлөгч/ хяналтын байгууллагын шаардлагаар тогтоосон хугацаанд живсэн усан замын тээврийн хэрэгслээ уснаас татаж гаргах ба боломжгүй тохиолдолд түүнийг зайлуулах буюу устгана;

11.5.3. Живсэн, сураггүй алга болсон усан замын тээврийн хэрэгслүүдийн хувьд живсэн, сураггүй алга болсныг баталж буй баримт бичгүүд.

11.6. Усан замын тээврийн хэрэгслийг ашиглалтаас гаргахад шаардлагатай бүх баримт бичгүүдийг бүрдүүлсний дараа эзэмшигч /өмчлөгч/ усан замын тээврийн хэрэгслийг задалж ашиглалтаас гаргах тухай тушаал гаргах ба энэ нь усан замын тээврийн хэрэгслийг задлах үндэслэл болно. Эзэмшигч /өмчлөгч/-ийн өргөдөл гаргаснаар задалж, ашиглалтаас гаргасан усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасна.

## **12. Ашиглалтад шинээр орж буй усан замын тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага. Үүнд:**

- техникийн бүрэн бүтэн байдлын талаар комиссийн акт гаргуулах;
- батлагдсан орон тоогоор ажиллах мэргэжлийн баг бүрдүүлсэн байх;
- байвал зохих бичиг баримтуудыг тээврийн хэрэгслийн техникийн паспорт, хөдөлгүүрийн баримт бичиг г.м./ бүрдүүлсэн байх
- тогтоосон нормын дагуу авч явах сэлбэг, багаж хэрэгсэл, эд хөрөнгө бүрэн байх.

## **13. Усан замын тээврийн хэрэгслийн хэмжигч тоног төхөөрөмж, хэрэгслийн заалтын гажилт, хазайлтыг хянаж шалгах давтамж**

Хэмжигч хэрэгслийн нэр төрөл	Хяналт шалгалтын хэлбэр	Хянаж шалгах давтамж
Уурын тогоод, агаарын даралтат систем, шингэрүүлсэн хийн систем, гал унтраах систем, шингэнт шахуургын систем,		

жолоодлогын механизм, танкеруудын шингэний түвшинг болон зарцуулалтыг хэмжигч, шилжүүлэн шахагч ба хөвөгч цэнэглэгч станцын шингэний түвшинг болон зарцуулалтыг хэмжигч манометр, мановакуумметр, мөн зөөврийн мегаомметр.	төрийн	жилд нэг удаа
Усан замын тээврийн хэрэгслийн нэгдсэн системд суурилуулсан тоног төхөөрөмж, хэрэгсэл, механизмууд, хөдөлгүүрийн тосолгооны болон хөргөлтийн системүүдэд суурилуулсан манометр, мановакуумметр, пиromетр, термометр, тахометр, барометр, анемометр, секундомерүүд.	салбарын	хоёр жилд нэг удаа
Тог хэмжигч, хүчдэл хэмжигч, чадал хэмжигч, давтамж хэмжигч, фаз хэмжигч, синхроноскоп, самбарт мегаомметрүүд.	салбарын	гурван жилд нэг удаа
Хазайлт хэмжигчүүд	салбарын	дөрвөн жилд нэг удаа

#### **14. Усан замын тээврийн хэрэгсэл, объектод тавигдах үндсэн шаардлага**

14.1. Усан замын тээврийн хэрэгсэл, объект, техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл нь баталгаат хугацаатай байна. Баталгаат хугацаа-усан замын тээврийн хэрэгсэл, объектыг үйлдвэрлэх, засварлах, техникийн үйлчилгээ хийх зэрэг ажил гүйцэтгэгч нь техник ашиглалтын дүрмийг тогтоосон шаардлагын түвшинд сахин биелүүлсэн нөхцөлд усан замын тээврийн хэрэгсэл, объект тэдгээрийн техник, тоног төхөөрөмж, хэрэгслийн техник-ashiглалтын үзүүлэлтүүд хэвийн хэмжээндээ байх хугацааг баталгаажуулсан ашиглалтын хугацаа юм.

14.2. Усан замын тээврийн хэрэгсэл, объект эзэмшигч /өмчлөгч/-ийн мэргэжилтнүүд тээврийн хэрэгсэл, объектод хяналтын үзлэг хийнэ.

14.3. Усан замын тээврийн хэрэгсэл, объект, техник, тоног төхөөрөмж, хэрэгслийн техник-ashiглалтын үзүүлэлтүүдийг бодит амьдрал дээр тодорхойлох зорилгоор тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хэрэгслийг туршина.

14.4. Эзэмшигч /өмчлөгч/-ийн тогтоосон үзүүлэлтээр усан замын тээврийн хэрэгсэл, объект, техник, тоног төхөөрөмж, хэрэгслийн ажиллагааны бодит үзүүлэлтийг техникийн паспортад заасантай харьцуулах замаар болон усан замын тээврийн хэрэгслийг ашиглах явцад үүссэн эвдрэл, гэмтэл, зогсолтод дүн шинжилгээ хийж техник - ашиглалтын чанарыг үнэлнэ.

14.5. Хүчин төгөлдөр үйлчилж буй техникийн баримт бичгүүдээр тогтоосон үзүүлэлт, хэм хэмжээнд усан замын тээврийн хэрэгсэл, объект, техник, тоног төхөөрөмж, хэрэгслийн техникийн байдал нийцэж буй эсэхийг тодорхойлох үзлэгийг хийнэ.

14.6. Усан замын тээврийн хэрэгсэл, объект, техник, тоног төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, техник-ashiглалтын тогтоосон үзүүлэлтийг хангах зорилгоор техникийн ашиглалтын элемент гүйцэтгэх буюу сэргээн засварлана.

14.7. Усан замын тээврийн хэрэгслийн техник, тоног төхөөрөмж, хэрэгслийг багийн гишүүдэд хариуцуулж, тэдгээрийн техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих,

арчлах, хамгаалах үүрэг, хариуцлагыг ногдуулж буй баримт бичиг болох багийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг ахмад гаргана.

14.8. Усан замын тээврийн хэрэгсэл, түүний техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл найдвартай бүрэн ажиллагаатай, багийн гишүүдээр бүрэн хангагдсан, шаардлагатай бүх баримт бичиг болон хүнс, шатахуун зэрэг шаардлагатай бүх нөөцөө тавцан дээрээ ачаалсан байгаа тохиолдолд ашиглалтын бэлэн байдал хангасан гэж үзнэ.

14.9. Усан замын тээврийн тухай<sup>7</sup> хууль, усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, too бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журмын дагуу бүртгүүлж, ашиглалтын бэлэн байдлыг хангасан усан замын тээврийн хэрэгслийг ашиглалтад оруулна.

14.10. Усан замын тээврийн хэрэгслийн галын аюулаас хамгаалах, эрүүл ахуйн болон техникийн бэлэн байдал, түүний бүх төрлийн хангалт, багийн бүрэлдэхүүний иж бүрдэл, тэдний мэргэжлийн болон мэргэшлийн сайтар бэлтгэгдсэн байдал нь:

- хөвөлтийн аюулгүй байдал;
- багийн гишүүдийн аюулгүй байдал, тэдний ажиллах, амрах зайлшгүй нөхцөл;
- усан замын тээврийн хэрэгслээр зорчигчдын аюулгүй байдал, тэдний зорчих зайлшгүй нөхцөл;
- тээвэрлэж буй ачааны бүрэн бүтэн байдлыг хангах;
- усан замын тээврийн хэрэгслийн ажиллах техник-ashiглалтын өгөгдсөн үзүүлэлтүүд;
- усан замын тээврийн хэрэгслийг живэхээс хамгаалах тоног төхөөрөмж хэрэгслийг үр дүнтэй ашиглах болон бусад тээврийн хэрэгсэл, хүмүүст тусlamж үзүүлэх төхөөрөмж хэрэгслийг байнгын бэлэн байдалд байлгах;
- хүрээлэн буй орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх;
- бүрэн эрх олгогдсон хяналтын байгууллагын шаардлагад усан замын тээврийн хэрэгсэл, объектыг нийцүүлсэн байна.

14.11. Багийн гишүүдгүй, хөдөлгүүргүй усан замын тээврийн хэрэгслийг ашиглах зааварыг түүний эзэмшигч /өмчлөгч/ баталж, чирэгч-түлхэгчийн багийн гишүүдэд өгнө.

## **15. Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдалд тавигдах шаардлага**

15.1. Тээврийн хэрэгслийн их биеийн уртын хэмжээг Усан замын тээврийн тухай хуулийн<sup>8</sup> 10 дугаар зүйлийн 10.3-дахь заалтын дагуу тогтооно.

15.2. Усан замын багтаамжийн хэмжээг тээврийн хэрэгслийн овор хэмжээ, суулт, усны гүн ба гольдирлын өргөнийг үндэслэн тогтооно.

15.3. Нэг чиглэлийн хөвөлттэй замд тээврийн хэрэгслийн хамгийн өргөн хэсгийг 0.5 гэсэн итгэлцүүрээр, хоёр чиглэлийн хөвөлттэй зам /зэрэгцээд хөвөх буюу зөрөх/-д тээврийн хэрэгслийн хамгийн өргөн хэсгийг 0.3 гэсэн итгэлцүүрээр тус тус үржүүлж усан замын өргөний хамгийн бага хэмжээг тодорхойлно.

<sup>7</sup> Усан замын тээврийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2017 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

<sup>8</sup> Усан замын тээврийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2017 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

15.4. Усан замын тээврийн хэрэгслийн хэмжээ нь батлагдсан усан замын хэмжээнд тохирч байх ёстой ба усны гүнд ёроолын гадаргуугийн хамгийн доод талын цэгээс 70 см-ээс багагүй зайд үлдэж байхаар суултыг тооцоолно.

15.5. Усны ёроолын шавар хөрсийг ухаж малтах, тэгшлэх, цэвэрлэх замаар усны гүнийг нэмэгдүүлэх, эсвэл усны түвшинг шаардагдах хэмжээнд нэмэгдүүлэн тохируулах, эсвэл усан сан түүний барилга байгууламж, техник хэрэгслийг байнгын хэвийн ажиллагаатай болгох зэргээр тээврийн хэрэгсэл усан замаар осол аюулгүй аялан хөвөх нөхцлийг бүрдүүлнэ.

15.6. Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн үзлэг шалгалтыг усан замын улсын байцаагч болон аж ахуйн нэгж, байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хамтарсан комисс хийнэ. Усан замын зарим онцлог хэсэгт улсын байцаагчийн үзлэгийг тээврийн улирал эхлэхийн өмнө, усны түвшин ихсэх буюу үертэй үед, намар улирлын төгсгөлд, жилд нийтдээ 3 удаа явуулна.

15.7. Усан замын тээврийн хэрэгслийн ахмад, механик, тэдгээрийн туслахууд, цахилгааны механикч нар нь мэргэжлийн зэрэгтэй байх бөгөөд захиргаанаас тогтоосон журмын дагуу мэдлэг ур чадварыг нь шалган түвшин тогтоож зааварчлагаа өгнө.

15.8. Усан замын тээврийн хэрэгсэл гол мөрөн дээгүүр баригдсан гүүрийн доогуур гараахдаа гүүрэн дээр тавигдсан заалт тэмдгүүдийг баримтална.

## **16. Усан замын объектод тавигдах шаардлага:**

16.1. Усан замын тээврийн үйлчилгээ эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нутгийн захиргааны байгууллага нь усан замын дохио тэмдэг ба замын тэнхлэгийг жил бүр хавар, зуны улиралд тохируулан засч, шинэчлэн зохих газруудад байрлуулна.

16.2. Усан замын заалт, тэмдгүүдийн хэлбэр, хэмжээ, өнгө нь улсын стандартад тохирсон байна.

16.3. Усан доогуур тавигдсан инженерийн барилга байгууламж, кабель, хоолойг тээврийн хэрэгслийн хөвөлтөд нөлөөлөхгүйгээр усны ёроолын хөрсөнд шигтгэн суулгаж өгнө.

16.4. Усан замын тээврийн үйлчилгээ эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нутгийн захиргааны байгууллага усан замын дагуу байрлах барилга байгууламж, зогсоол, дохио тэмдэг, усан зам харилцааны бусад объектын хэвийн ажиллагааг ханган, усан замын объектыг засварлах, бүтээн босгох ажлын хугацаа, ажиллах хүчний бүрэлдэхүүнийг тогтоож, шаардагдах бэлтгэлийг хангаж ажлын гүйцэтгэлийг хянана.

16.5. Усан замын болон түүний эргийн дагуу байгуулагдсан барилга байгууламж /гүүр, хаалт г.м бусад объект/ нь үйл ажиллагаагаа зориулалтын дагуу хэвийн явуулах боломжтой баригдсан байхаас гадна усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

16.6. Усан замын төв буудал, зогсоол, үйлчилгээний барилга байгууламжийн орчимд шинээр объект барьж байгуулах, засвар үйлчилгээ хийж гүйцэтгэх шаардлага гарсан тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч гүйцэтгэнэ.

## **17. Усан замын тээврийн хэрэгслийд тавигдах шаардлага**

17.1. Ашиглалтад байгаа усан замын тээврийн хэрэгслийн их бие болон эд ангийн элэгдэл нь үйлдвэрлэгч, зохиогчийн баримт бичгээр тогтоосон хэмжээнээс илүүгүй байх ба элэгдлийн хэмжээг эрх бүхий байгууллага тээврийн хэрэгслийн төрөл тус бүр дээр тусгайлан тогтооно.

17.2. Усан замын тээврийн хэрэгслийн их биеийн хоёр хажууд даацын тэмдэглээ буюу усанд суух өндөр болон усны түвшингээс дээш байрлах хэмжээсийн заалт тэмдгийг /ачаалах тэмдэг/ бүртгэлийн журамд заасны дагуу зохих өнгийн будгаар будаж байрлуулна.

18.1. Үндсэн ба туслах хөдөлгүүрийн түлш зарцуулалт өөрийн хүчин чадлын хэмжээнээс хэтрэхгүй байх ба дараах шаардлагыг хангана. Үүнд:

- 18.1.1. эргэлт хязгаарлагч, хамгаалагчийн найдвартай ажиллагаа;
- 18.1.2. хөдөлгүүрт тосолгоо хийгдсэн, хөргөлтийн болон түлшний системүүдийн ажиллагаа хэвийн байх;
- 18.1.3. хөдөлгүүрийн хүчийг цилиндр бүрт жигд тохируулах;
- 18.1.4. хөдөлгүүрийн эргэлтийг тогтоосон хэмжээнд байлгах.

19.0. Үндсэн ба туслах машин механизмууд, жолоодлогын автомат хамгаалалт бүхий төв удирдлагатай бол машин ангиудыг ээлжгүй ажиллуулж болно.

19.1. Дараах гэмтэл гарсан бол үндсэн ба туслах хөдөлгүүрийг ажиллуулахгүй. Үүнд:

- 19.1.1. цилиндрийн гавал, втулка, хөдлөх эд анги, масло, түлш болон хийн хоолойд цав гарсан;
- 19.1.2. машин эргэлт, шилжүүлэлт болон моторын эд анgid гэмтэл гарсан;
- 19.1.3. эргэлт хязгаарлагчид гэмтэл гарсан;
- 19.1.4. цилиндрээс хий алдсан;
- 19.1.5. хөдлөх эд ангиудад хэвийн бус чимээ, цохио гарах болсон;
- 19.1.6. агаар шахалт хэвийн бус хэмжээтэй байх;
- 19.1.7. цилиндр, картер ба тосны системд ус орсон;
- 19.1.8. цилиндрийн гавлын хамгаалах хавхлагийн тохиргоо алдагдсан;
- 19.1.9. тос, түлш болон хөргөлтийн шахуургуудын ажиллагаа алдагдсан.

20. Усан замын тээврийн хэрэгслийг аяллад гарахын өмнө ахмад, механик техникийн үзлэг хийх ба дараах зөрчил дутагдал илэрвэл хөвөлтөд гаргахгүй. Үүнд:

- 20.1. Усан замын тээврийн хэрэгслийн туслах механизмууд цахилгаан хөдөлгүүртэй бол ерөнхий цахилгаан үүсгүүрийн нэг нь ажиллагаагүй болсон;
- 20.2. Осол, аваарийн цахилгаан үүсгүүр гэмтсэн;
- 20.3. Залуур, тэжээгч шахуурга, хөргөлтийн системийн шахуургын хөдөлгүүр гэмтсэн;
- 20.4. Дохионы гэрэл гэрэлтүүлэг ажиллагаагүй болсон;
- 20.5. Сэнсний далбаа хугарсан, боолтын шплинт элэгдсэн.

21. Усан онгоцны бүх цахилгаан тоноглол техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хангасан байна. Үүнд:

- 21.1. Усан замын тээврийн хэрэгслийн цахилгаан тоноглолын ажиллагаа нь радио дамжуулалт буюу радар, луужингийн хэвийн ажиллагаанд нөлөөлөхгүй ажиллагаатай байх ба цахилгаан тасалдах, оч үсрэх, хэт халах гэх мэт аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байна;
- 21.2. Бүх цахилгаан тоноглолын үзлэгийг хийхдээ цахилгаан гүйдлийг салгасны үндсэн дээр сард нэгээс доошгүй удаа зохих журам, зааврын дагуу хийж гүйцэтгэнэ;
- 21.3. Утас, кабелийн бүрхүүлийн чанар, цахилгаан машин, аппаратын хуваарилалтын самбарыг шалгахдаа цахилгаан гүйдлийг заавал салгасан байна;
- 21.4. Аваарийн гэрэл богино хугацаанд асч байгаа эсэхийг байнга шалгана;
- 21.5. Усан замын тээврийн хэрэгсэл нь цахилгаан хэмжих багаж хэрэгслээр хангагдсан байх ба заалтын хэмжүүрийг энэ дүрмийн 13 дахь заалтад заасны дагуу эргэлзээтэй нөхцөлд тухай бүрт нь хэмжил зүйн газарт шалгуулна;
- 21.6. Нэг цахилгаан үүсгүүрийн ачааллыг нөгөөд шилжүүлэлгүйгээр ажиллагааг үл зогсооно;
- 21.7. Цахилгаан самбарын өрөөнд зайлшгүй байх эд зүйлийн жагсаалт:
- 21.7.1. нөөц гал хамгаалагч, дохионы буюу хяналтын гэрэл;
- 21.7.2. засварын багаж;
- 21.7.3. резин бээлий ба дэвсгэр, нүдний шил, хамгаалах бүрхүүлтэй багаж;
- 21.7.4. эмийн сан;
- 21.7.5. галын хор;
- 21.7.6. гар чийдэн, шаардлагатай багаж, түлхүүрүүд.
- 21.8. Цахилгаан машиныг дараах тохиолдолд ажиллуулахгүй. Үүнд:
- 21.8.1. кабель утасны гадаргуу халсан;
- 21.8.2. цуглуулагч /коллектор/-д 2 баллаас дээш оч үсэрсэн;
- 21.8.3. асаах ба тохируулах аппарат хэрэгсэл ажиллагаагүй болсон;
- 21.8.4. машиныг гэмтээж болох үрэлт, цохио үүссэн;
- 21.8.5. зангууны ороомогт богино холбоо үүссэн.
- 21.9. Цахилгаан хөдөлгүүрийг дараах тохиолдолд нэн даруй зогсооно. Үүнд:
- 21.9.1. хөдөлгүүр халах, хиншүү үнэртэх, утаа ба гал гарах;
- 21.9.2. хөдөлгүүрийн голын гажилтаас доргио, чичиргээ үүссэн;
- 21.9.3. хөдөлгөөнтэй эд ангид хүний хувцас татагдсан.
- 21.10. 25 вт-аас дээш хүчдэлтэй бүх цахилгаан тоноглолын төмөрлөг хэсгийг заавал газардуулсан байна.
- 21.10.1. хүчдэлийг салгасны дараа гал хамгаалагчийг сольж хэвшинэ. Хэрэв ийм бололцоогүй бол ачааллыг бууруулж хамгаалах хэрэгслийг солино.
- 21.10.2. хамгаалах хэрэгслийн хүчинтэй хугацааг тогтмол шалгаж байх ба зориулалтаас өөр шалтгаанаар ашиглахыг хориглоно.
- 21.10.3. зөөврийн гэрлийг нефть шатахуун тээвэрлэгч онгоц болон шатаж дэлбэрэх ачааны ойролцоо үл хэрэглэнэ. Мөн өндөр хүчдэлээс аль болох хол байлгаж гэрлийг анхаарал болгоомжгүйгээр түүнд холбохгүй байх ба бүрхүүлд ус нэвчихгүй байх нөхцлөөр хангана.
22. Залуурын тоноглол нь аяллын ямар ч нөхцөлд усан замын тээврийн хэрэгслийг найдвартай залах үндсэн нөхцөл болох дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 22.1. тороос болон залуурын голын элэгдэл тогтоосон хэм хэмжээнээс хэтрээгүй байх;
- 22.2. залуурын тороосыг ямагт чангальсан байх;
- 22.3. 0-45 градус хүртэл залуурын эргэх хугацаа механикжсан залуурын хувьд 30 секунд, гар ажиллагаатай залуурын хувьд 2 минутаас ихгүй байх;

22.4. үндсэн залуураас нөөц залуурын ажиллагаанд шилжих хугацаа нэг минутаас хэтрэхгүй байх;

22.5. Жолоодлогын палуб /тавцан/, онгоцны тавцантай үрэлдэхээргүй зйтай, арааны элэгдэл нь хэвийн ажиллагаанд нөлөөлөхөөргүй байх;

22.6. Залуурын машины цахилгааны контактууд цэвэр найдвартай ажиллагаатай байх.

22.7. Тороос, олсны чанаарын шалгалтыг хийлгүйгээр ашиглахгүй.

22.8. Усан замын тээврийн хэрэгсэл хайдах болон залуур ямар нэгэн зүйлд хүчтэйгээр хүрсэн тохиолдолд ахмад, механик үзлэгийг чанд нямбай, чанартай хийж гүйцэтгэх ба хэрэв эвдрэл гарсан бол нөхцөл, шалтгааныг тогтоох үүрэг хүлээнэ.

22.9. Залуурын ажиллагаа гэмтэлтэй тээврийн хэрэгслийг аялалд гаргахгүй.

22.10. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч өөрийн радио холбооны станцаар эрэг, зогсоол, буудлын диспетчертэй байнгын холбоотой байна.

22.11. Радио холбооны станцыг ашиглахад дараахь баримтыг бүрдүүлсэн байна.

Үүнд:

22.11.1. радио холбоо ашиглах зөвшөөрөл;

22.11.2. радио станцын гэрчилгээ;

22.11.3. ээлжийн журнал;

22.11.4. нэвтрүүлгийн долгионы хуваарь;

22.11.5. радио холбооны дүрэм;

22.11.6. техникийн аюулгүйн дүрэм;

22.11.7. ашиглалтын дүрэм ба заавар.

22.12. Усан замын тээврийн хэрэгслийн радио холбоог зохих мэргэжлийн хүн ажиллуулах бөгөөд холбооны хэвийн ажиллагааг найдвартай хангаж, техникийн үзлэгийг тогтмол хийнэ.

23. Усан замын тээврийн хэрэгслийн үндсэн машин, тоног төхөөрөмж өөрийн ашиглалтын хугацаанд тасралтгүй ажиллагааг хангаж байхаас гадна тэдгээрийн туслах механизмууд ажиллагаанд ямагт бэлэн байна.

23.1. Жолоодлогын байрны болон машин ангийн хяналт, хэмжүүрийн самбарын хэрэгсэл бүрэн бүтэн ажиллагааг хангасан байна.

23.2. Усан замын тээврийн хэрэгсэлд усны, уурын, түлш, тос, агаар дамжуулалтын хоолой болон цахилгаан шугамын схемүүдэд суурилуулсан хэмжигч бүх хэрэгслийг хэмжил зүйн эрх бүхий байгууллагаас баталгаажуулан лацадсан байх бөгөөд ашиглалтын үед энэ дүрмийн 13-т тогтоосон хугацаанд хяналт шалгалт хийж байна.

23.3. Тогооны болон бусад даралтат савны хамгаалах хавхлагийг энэ дүрмийн 13-т заасан эрх бүхий этгээдээр лацдуулна.

23.4. Усан замын тээврийн хэрэгслийн механизмд дараахь өөрчлөлт оруулахгүй.

Үүнд:

23.4.1. тухайн нөхцөлд даралттай байгаа тогоо болон бусад даралтат савыг засварлах;

23.4.2. эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр даралтын ба бусад хэмжүүрийн хэрэгслийн байршлыг өөрчлөх, тохиргоо хийх.

24. Тээврийн хэрэгслийн механизм ашиглалтын зааварт дурьдсан хугацаанд машин механизм бүрийн эд ангийн элэгдлийг тооцоолж, дүнг журналд тэмдэглэнэ.

25. Жолоодлогын байр ба машин, тогооны ангид байрлуулсан хэмжүүрийн тоног төхөөрөмжийг гэрэлтүүлэх аваарийн хэрэгслээр тоноглосон байна.

26. Механизм, систем бүрийн нээлхийд зориулалтын тэмдэг, тэмдэглэгээ хийж, дотор нь агуулагдах ус, шингэн, уурын хөдөлгөөний чигийг сумаар заана.

27. Усан замын тээврийн хэрэгсэл нэг бүрийн машины эд ангид тусгай маягтын дагуу батлагдсан машины дэвтэр /журнал/ байх ба механик хөтөлнө.

28. Шахагдсан хийн баллоны тоо ширхэг, багтаамж нь үндсэн, туслах хөдөлгүүрүүдийг асаах, эргэлт шилжүүлэхэд хүрэлцэхүйц тоо хэмжээтэй байх ба дараах баллонд шахалт хийхгүй.

28.1. цав гарсан, хий алдсан;

28.2. даралт хоногт 10 хүртэл хувиар буурч хий алдсан;

28.3. хамгаалах хавхлаг ба манометр гэмтэлтэй;

28.4. тослог уур, чийг гаргах илүү хоолой байрлуулаагүй.

29. Бүх даралтат савыг тогтоосон хугацаанд заавал шалгаж байх ба баллоныг цэнэглэх бүрийн өмнө цэвэрлэнэ.

30. Хийн шахуургад дараах гэмтэл гарвал ажиллуулахгүй.

30.1. үндсэн эд ангиудад гажилт, цууралт, цав үүссэн;

30.2. агаарын хоолойнууд хий алдсан;

30.3. тосны ба хөргөлтийн системд гэмтэл гарсан;

30.4. хамгаалах хавхлагад тохиргоо хийгдээгүй буюу гэмтэлтэй;

30.5. хөдлөх эд ангиудад хэвийн бус цохио, чимээ үүссэн.

31. Аяллын ямар ч нөхцөлд зангууг яаралтай буулгах ба татахад бэлэн байлгах шаардлагыг хангахын тулд дараах нөхцлийг биелүүлсэн байна:

31.1. зангуу хураагч нь 2 зангууг нэгэн зэрэг тогтоосон хугацаанд татаж авах хүчин чадалтай байх;

31.2. зангууны гинжийг хайрцагт хураан төгсгөлийг онгоцны их биед найдвартай бэхэлсэн байх;

31.3. гинжний металийн диаметрийн элэгдэл 20%-аас хэтрэхгүй байх;

31.4. зангуу хураагч болон шпилийн тоормоз, гинжний түгжээ найдвартай байх;

32. Зангуу нь бүрэн бус ажиллагаатай усан замын тээврийн хэрэгслийг хөвөлтөд гаргахгүй.

33. Усан замын тээврийн хэрэгслийн хуурай ачаа болон түүний тоноглолын бүрэн бүтэн байдлыг ахмад, механик үе үе шалгана.

34. Ачааны тоноглол, механизмын дараах гэмтэлтэй усан замын тээврийн хэрэгслийг аялалд гаргахгүй. Үүнд:

34.1. тоормозны механизм ажиллахгүй буюу гэмтэлтэй;

34.2. өргүүрийн сум, тулгуур гэмтсэн буюу бэхэлгээ муу хийгдсэн;

34.3. олс, тороосны дамрын гол 15 болон түүнээс дээш хувийн элэгдэлтэй;

34.4. тороосны 6 диаметр урт тутам утасны 10 хувь буюу нэг сүлжээ тасарсан;

34.5. эрэг, шураг болон их биеийн дамарт цав, гажилт гарсан.

35. Усан замын тээврийн хэрэгслийн шурагын өдөр, шөнийн дохио, радио антена, буулгах, босгох механизм ямагт бүрэн ажиллагаатай байна.

36. Өдөр, шөнийн дохионууд /яндан, дуут дохио (сирен), дэнлүү, дохио өгөх туг, хонх/ цаг агаарын ямар ч нөхцөлд сонсогдохуйц, үзэгдэхүйц байхаар тоноглогдсон байна. Тээврийн хэрэгслийн дохиог өөр зориулалтаар хэрэглэхгүй.

37. Усан замын тээврийн хэрэгслийн гадна болон дотор талд байрлах харилцаа холбооны хэрэгслийн ажиллагааг аялалд гарахын өмнө ахмад өөрийн биеэр шалгаж бэлтгэсэн байх ба дутагдал, гэмтэл илэрсэн тохиолдолд хөвөлтөд гарахгүй.

38. Гал унтраах бүх хэрэгслийг гарын дор байршилд байрлуулах ба хэрэглэхэд байнгын бэлэн байдалд байна. Гал унтраах хэрэгслийг зориулалтын бус үйл ажиллагаанд хэрэглэхийг хориглоно.

39. Түргэн шатаж дэлбэрэх зэрэглэл бүхий аюултай ачаа /нефть болон бусад/ барааг тухайн төрлийн ачаа тээвэрлэхэд мөрддөг дүрмийн дагуу гал унтраах тусгай хэрэгслээр тоноғлосон байна.
40. Гал унтраах багаж хэрэгсэл бүрэн бус ажиллагаатай болон холбогдох журмын шаардлагад нийцээгүй тохиолдолд аялалд гарахгүй.
41. Аврах хэрэгслийн тоо, чанар, тэдгээрийн байршил тогтоосон хэмжээнд нийцэж байна.
42. Усан замын тээврийн хэрэгслийг аялалд гарахын өмнө ахмад аврах хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, "Усанд хүн уналаа" сургуулийн түгшүүрийг удирдан явуулж энэ тухай тэмдэглэл хөтөлнө. Энэ сургуулитаар дараах ажиллагааг шалгана. Үүнд:
- 42.1. зангуу татах, буулгах механизм тогтоосон хугацаанд хэвийн ажиллаж буй эсэх;
- 42.2. аврах цагираг хөвүүр бүрэн, бүтэн байх ба аврах завинд ус шүүрэхгүй байх.
43. Дараах шаардлага хангагүй усан тээврийн хэрэгслийг аялалд гаргахгүй. Үүнд:
- 43.1. аврах хэрэгслийн тоо хэмжээ тогтоосон тоо хэмжээнд хүрэхгүй байх;
- 43.2. аврах хэрэгслийн техникийн байдалд хяналтын байгууллага хангалтгүй үнэлгээ өгсөн;
- 43.3. буулгах механизмын ажиллагаа хэвийн бус, буух хугацаа тогтоосон хугацаанаас хэтэрсэн.
44. Ашиглалтанд байгаа тээврийн хэрэгсэл нэг бүрийг бүртгэлийн журмын шаардлагад заасан төхөөрөмж хэрэгслээр хангасан байна.
45. ЖПС, луужин бүрэн ажиллагаатай, замын зураг хянагдсан байна.
46. Аяллын чиглэл, замнал нь усан замын тээврийн хөдөлгөөний аюулгүй ажиллагаа, үйлчилгээгээр иргэдийг хангах, зорчигч болон ачаа тээвэрлэлтийг бага зардлаар өндөр бүтээмжтэй зохион байгуулахад чиглэгдэж батлагдсан байна.
47. Орон нутгийн усан замын хөвөлтийн чиглэлийг нутгийн захиргааны байгууллага, усан замын үйлчилгээ эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжийн саналыг үндэслэн байгаль орчны хяналтын байгууллагатай зөвшилцөн баталснаар хүчин төгөлдөр болж, аяллын бүх хугацаанд багийн бүрэлдэхүүн, жолоочийн заавал мөрдөх журам болно.
48. Гол мөрний усан замын тээврийн хэрэгслийн засвар, өвлийн зогсолтын хугацаанд хийх урсгал ба дунд засварыг багийн бүрэлдэхүүн ахмад, механикийн удирдлагын дор хийж гүйцэтгэнэ.
49. Усан замын тээврийн хэрэгслийг зориулалтын бус аливаа үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно. Зайлшгүй шаардлага, хэрэгцээ гарсан тохиолдолд тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр ашиглаж болно.
50. Техник ашиглалтын дүрмийн заалтыг биелүүлээгүй буюу зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авах ба гэмт хэргийн шинжтэй тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

—оOo—